

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

## 2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг

|  |        |
|--|--------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>   | 1      |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>        | 2 – 6  |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | 7 – 53 |

|    |   |         |
|----|---|---------|
| 1. | <i>Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлт /Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/</i> | 9 – 17  |
| 2. | <i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/</i>  | 17 – 19 |
| 3. | <i>Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан</i>   | 19 – 53 |

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны 4 дүгээр сарын 15-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 31 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 51.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 48 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.*

*Томилолттой: Г.Лувсанжамц, Л.Соронзонболд, Б.Уянга, Д.Үүрийнтуяа;  
Чөлөөтэй: Ч.Анар, Б.Жаргалан, М.Мандхай, Г.Очирбат;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Б.Жавхлан;  
Тасалсан: Ж.Алдаржавхлан, Ш.Бямбасүрэн, Б.Найдалаа, О.Цогтгэрэл.*

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал үг хэлэв.

***Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлт /Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Б.Ууганцэцэг, Т.Билэг-Өрнөх, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулав.

Цэцийн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, Р.Сэддорж нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн “84.2.2.энэ хуулийн 84.2.1-д заасны дагуу Байнгын хороод цэцийн дүгнэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль, тогтоолын Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр, хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулах;” гэж заасны дагуу санал хураалт явуулав.*

**Р.Сэддорж:** 1.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн

байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**2.** Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**3.** Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад “хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг үг хэлэв.

**Р.Сэддорж:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 11 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Шадар сайдын ажлын албаны зөвлөх Х.Оюунцэцэг, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Болор-Эрдэнэ, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга В.Түвшинжаргал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ц.Өнөрнасан, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Ү.Ганболд, “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, Бүсчилсэн хөгжлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал Д.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Г.Эрдэнэбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Б.Ууганцэцэг, Т.Билэг-Өрнөх, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын референт Ч.Сарантуяа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтэд хийсэн дүн шинжилгээний тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, О.Батнайрамдал, С.Цэнгүүн, М.Бадамсүрэн, Б.Пунсалмаа нарын тавьсан асуултад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ц.Өнөрнасан, “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Г.Эрдэнэбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, М.Энхцэцэг, Р.Сэддорж нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцлээ.

*Уг асуудлыг 12 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 05 минут үргэлжилж, 31 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр 12 цаг 53 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг  
Төрийн ордны “Их засаг” танхим  
10 цаг 48 минут

### ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Р.Сэддорж:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд оролцож байгаа гишүүд.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Ринчиндоржийн Батболд, Отгоншарын Батнайрамдал, Нацагдоржийн Батсүмбэрэл, Пүрэвийн Батчимэг, Хүрэлбаатарын Булгантуяа, Пүрэвжавын Ганзориг, Батжаргалын Заяабал, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Эрдэнэбилэгийн Одбаяр, Ренчинбямбын Сэддорж, Агваанлуvsангийн Ундраа, Саруулсайханы Цэнгүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Мөнхчулууны Энхцэцэг нарын гишүүд оролцож байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 51.6 хувьд бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлт.

Үндсэн хуулийн цэцээс 2026 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр ирүүлсэн.

Хоёр.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан.

Гурав.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Санхүүгийн хоршооны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу?  
О.Батнайрамдал гишүүн.

**О.Батнайрамдал:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Өнөөдөр хэлэлцэх асуудлын жагсаалтад Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланд хийсэн дүн шинжилгээ. Нэг ёсондоо Улсын Их Хурлаас гаргасан хууль, тогтоол түүнийг Засгийн газар хэрхэн хэрэгжүүлсэнд дүгнэлт хийсэн талаар бид өнөөдөр хэлэлцэгдэж байгаа юм байна.

Тэгэхээр энэ магадгүй бидний бүтэн жилийн туршид хэлэлцэх хамгийн чухал зүйлүүдийн нэг байхгүй юу. Улсын Их Хурлаас хууль батлаад л байдаг, тогтоол батлаад л байдаг. Гүйцэтгэх засаглал дээр очоод хэрхэн хэрэгжсэн талаар бид өнөөдөр 2025 оны бүтэн жилийн эцсийн байдлаар дүгнэлт хийх гэж байна шүү дээ.

Тэгэхээр энэ маш чухал ач холбогдолтой дүн шинжилгээг Засгийн газар хэрхэн хэрэгжүүлсэн талаар бид хэлэлцэх гэж байгаа учраас энэ асуудал дээр эхлэхээс нь өмнө хэлмээр байна л даа. Яг хариуцсан сайдууд болон нэгтгэж уяж байгаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга бүгдээрээ байх хэрэгтэй.

Түүнээс биш буцаад бүх л жилийн турш Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийг, хууль тогтоолыг Засгийн газар хэрхэн хэрэгжүүлсэн талаар тайлагнах болтол хэдэн газрын дарга, Төрийн нарийнаас бид асуулт асууж болохгүй шүү дээ.

Тийм учраас Эдийн засгийн байнгын хорооны дарга Танаас хүсэх хүсэлт байна л даа. Яг энэ асуудлыг хэлэлцэх үед хариуцсан сайд нар, хариуцсан одоо шаардлагатай албан тушаалтнууд бүгд байлгахыг хүсье. Баярлалаа.

**Р.Сэддорж:** О.Батнайрамдал гишүүний гаргасан саналыг хүлээж авч байна.

Тэгээд хэлэлцэх асуудлын хамгийн сүүлд нь оруулах уу? Тийм.

Тэгээд нөгөө Засгийн хурал тараад сайдууд ирэх байх.

Тэгэхээр бидний хурал шууд явж байгаа учраас сонс байх. Ийм учраас хэлэлцэх асуудлын хоёрдугаар асуудлыг буюу Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэх асуудлын гуравдугаар асуудалд оруулъя.

Ингээд Улсын Их Хурлын гишүүний гаргасан саналаар Засгийн газрын сайдууд, Хэрэг эрхлэх газрын дарга энэ асуудал дээр орж ирэхийг хүсье. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

---

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлт**  
/Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

---

Хэлэлцэх асуудал. Нэг.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

**О.Батнайрамдал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсгийн “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “...Улсын дээд шүүхийн Тамгын газар...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэхийг тогтоолгохоор иргэн С.Номынбаясгалангийн гаргасан мэдээлэл, Монгол Улсын дээд шүүхийн хүсэлтээр Үндсэн хуулийн цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн байна.

Уг маргаанд Улсын Их Хурлыг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр миний бие Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 159 дүгээр захирамжаар томилогдон ажиллалаа.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн Дунд суудлын хуралдаанаар уг маргааныг хянан шийдвэрлэсэн бөгөөд миний бие 2025 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн УИХ-03/5568 дугаар албан бичгээр хариу тайлбарыг хүргүүлсэн.

---

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан /даргалагч/, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар /илтгэгч/, О.Мөнхсайхан, Б.Болдбаатар, Р.Батрагчаа нарын бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж, Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон дүгнэлт гаргасан байна.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийн дүгнэх хэсгийг Та бүхэнд товчлон танилцуулъя.

“1.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “...Улсын дээд шүүхийн Тамгын газар...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “...шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй...”, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад “хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.” гэж заасанд нийцээгүй байна.

2.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “...Улсын дээд шүүхийн Тамгын газар...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй ...” гэж заасныг зөрчөөгүй байна.

3.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “...Улсын дээд шүүхийн Тамгын газар...” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй...” гэж дүгнэсэн байна.

Байнгын хорооны эрхэм гишүүдээ,

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэхийг хүсье.

**Р.Сэддорж:** О.Батнайрамдал гишүүнд баярлалаа.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

М.Бадамсүрэн гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн.

**М.Бадамсүрэн:** Энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй гэсэн саналтай байгаа.

Яагаад гэхээр угаасаа хоёр асуудлыг хэрэгжүүлэхэд тулгараад байгаа юм билээ. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль дээр. Жишээлбэл,

▷ **Нэгдүгээрт,** Улсын дээд шүүх бүртгэнэ гэсэн.

Тэгээд Улсын дээд шүүх болохоор манайх бүртгэхгүй гээд энэ хууль хэрэгжихгүй яваад байгаа.

Тэгэхээр мэргэжлийн холбооны ангиллыг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу Сангийн сайд баталж байгаа юм.

Тэгээд энэ ангид нийцүүлээд мэргэжлийн олон холбоодыг цаашид үр дүнтэй ажиллуулахад чиглэсэн хууль л даа.

Тэгэхээр үүнийг дээд шүүх биш улсын бүртгэлийн байгууллага бүртгэх нь зүйтэй.

Тэгээд Төрийн бус байгууллагын тухай хуулиар бүртгэнэ гээд дунд нь энэ хууль хэрэгжихгүй их удаан явсанд би их харамсаад байгаа юм. Яагаад гэхээр төрийн олон өгдөг тэр шийдвэр, зөвшөөрөл, хариуцах юмнуудыг мэргэжлийн нэгдсэн холбоогоор хэрэгжүүлдэг болгоё. Энд хариуцдаг болгоё гэдэг гол үзэл санаатай батлагдсан хууль шүү дээ.

Тэгэхээр үүнийг нэгдүгээрт улсын бүртгэлийн байгууллага бүртгэдэг болгож өөрчлөх хэрэгтэй.

Дүгнэлтийг хүлээн авмагцаа яаралтай хуульдаа өөрчлөлт оруулаад, тэгээд батлуулаад хэрэгжүүлээд явах нь зөв гэж үзэж байгаа юм.

▷ **Хоёрдугаарт нь,** 5.3.2 гээд заалт байгаа.

Тухайн салбарын холбоодыг бүртгэхэд үзүүлэх шалгуур дээр нь тухайн салбарын нийт аж ахуйн нэгжийн бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа 50-иас дээш хувь нь байсан тохиолдолд бүртгэнэ гэсэн утгатай заалт байгаа.

Тэгэхээр үүнийг яаж хэмжих юм гэдэг нь тодорхойгүй.

Тэгэхээр би мэргэжлийн олон холбоотой уулзалт хийсэн. 50 гаруй холбоотой уулзалт хийсэн. Эндээс тодорхой санал гарч байгаа юм.

Тэгэхээр энэ дурдагдсан уу? Зөвхөн гаргасан гомдлынхоо хүрээнд явсан юм уу?

Тухайн салбарын боловсруулах үйлдвэрийн салбарын 50-иас дээш хувийг хамруулсан байж тэр холбоог бүртгэнэ гэж байгаа байхгүй юу.

Тэгээд тэрийг яаж нотлох гэж байгаа юм? Одоо үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийх нь 50-иас дээш хувийг гэж байгаа юм. Үүнийг нотлох боломжгүй гэж мэргэжлийн нэгдсэн холбоодын дийлэнх нь үзэж байгаа.

Тийм учраас үүнийг яаж өөрчлөх гэж байгаа вэ?

▷ **Гуравдугаарт нь**, Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас мэргэжлийн нэгдсэн холбоод ямар ялгаатай ажиллах вэ? Эсвэл яаж уялдаж ажиллах вэ?

Энэ нь цэц дээр маргаан болох үеэр дурдагдсан асуудал байдаг юм уу? Зөвхөн энэ хүрээндээ явсан юм уу? Ер нь цаашид манай Байнгын хороо ямар бодолтой байгаа вэ? Байнгын хорооны даргаас яг энэ асуултыг. Баярлалаа.

**Р.Сэддорж:** О.Батнайрамдал гишүүн хариулъя.

**О.Батнайрамдал:** М.Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя.

Тантай санал нэг байна. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль 2024 онд батлагдсан юм билээ.

Тэгээд энэ хууль дээрээ бид мэргэжлийн нэгдсэн холбоодыг Улсын дээд шүүхэд бүртгэнэ гэдэг заалтыг тухайн үедээ ажлын хэсгээс оруулж Улсын Их Хурлаар баталсан юм байна. Тэгээд өнөөдөр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт таны хоёр дахь гурав дахь асуултад хамаарахаар байна л даа.

Ерөөсөө энэ заалт дээр маргаан гарсан байгаа. Мэргэжлийн нэгдсэн холбоод бас нэг Төрийн бус байгууллага

Тэгэхээр үүний бүртгэлийг Улсын дээд шүүх дээр хийх нь зөв үү, үгүй юу. Энэ хүрээнд л ерөөсөө дүгнэлт гарсан байгаа.

Улсын дээд шүүхийн дүгнэлт нэг ёсондоо мэргэжлийн нэгдсэн холбоодын бүртгэлийг Улсын дээд шүүх дээр бүртгэх нь чиг үүргийн хувьд Үндсэн хуулийн эрх мэдлийн хуваарилалтын зарчимтай зөрчилдөж байна.

Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан Улсын дээд шүүхийн үндсэн чиг үүргийн агуулгатай нийцэхгүй байна.

Мөн Үндсэн хуулийн тодорхой хэд хэдэн заалтыг зөрчсөн учраас Улсын дээд шүүх дээр бүртгэхээс түдгэлзүүлсэн ийм шийдвэр гарсан байгаа юм.

Тэгэхээр Улсын дээд шүүхийн энэхүү дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороон дээр хэлэлцээд бид чуулганаар оруулж үүнийг бид шийдвэрлэнэ. Хэрвээ бид шийдвэртээ энэ Улсын дээд шүүхийн дүгнэлтийг хүлээж авах юм бол таны хэлсэнчлэн яаралтай хуулийн хугацаатай юм билээ. Тухайн хугацаандаа багтаж хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүснэ. Энэ агуулгаараа Эдийн засгийн байнгын хороон дээр хамаарч байгаа юм билээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Та хэллээ. Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хуулийн 5.2-т заасан тэр 50 хувиас дээш байж мэргэжлийн нэгдсэн холбоо болно гээд. Энэ өнөөдөр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд хамаарахгүй.

Үндсэн хуулийн дүгнэлтэд ерөөсөө л энэ бүртгэлийн ажил Улсын дээд шүүх дээр бүртгэх, үгүй эсэх л хамаарч дүгнэлт гарсан байгаа юм.

Яах вэ, энэ дүгнэлт дээр бас нэг сонирхолтой жишээ татсан байгаа юм л даа. 2024 онд энэ хууль хэрэгжсэнээс хойш Мэргэжлийн нэгдсэн холбоо эрх зүйн байдлын тухай хуульд мөрдөгдөж эхэлснээс хойш “Хуурай замын тээврийн салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо” гэдэг ганцхан байгууллага Улсын дээд шүүх дээр бүртгүүлэхээр хандсан юм байна.

Хүсэлтээ хүргүүлсэн боловч таны хэлж байгаачлан бас л янз бүрийн асуудал гараад Хот хоорондын тээвэр эрхлэгчдийн холбооны гишүүн 8 аж ахуйн нэгж бүртгүүлэхээр явж байгаа байгууллага биднийг төлөөлөхгүй гэж гомдол гаргасан байгаа юм.

Тэгээд энэ гомдол нь нэгдмэл ашиг сонирхолтой асуудал хянагдахаар асуудал үүсгээд л байж л байгаа юм байна л даа.

Тэгэхээр энэ хуулийг ч гэсэн бид ер нь дахиж харах нь зүйтэй юм байна. Таны хэлж байгаачлан тэр 5.2 дээр 50 хувиас дээш гэх мэтчилэн хоорондоо нэгдсэн холбоогоо хүлээн зөвшөөрөх асуудал нь хүртэл ингээд асуудал дагуулсан хэвээр байгаа юм байна. Ганцхан холбоо бүртгүүлсэн нь асуудал дагуулж байгаа.

Үүнийг Та хэллээ. Өчигдөр Хууль зүйн байнгын хороон дээр ч гэсэн П.Сайнзориг гишүүн хэлж байна л даа. Худалдаа, аж үйлдвэрийн мэргэжлийн холбоод бүртгэлийн ажил түүгээрээ явах хэрэгтэй.

Тэгэхээр энэ дээр Улсын дээд шүүх дээр бүртгэх үү, үгүй юу гэдэг асуудлаа эхлээд шийдээд, тэгээд цаашдаа Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт өгөх оруулах, цаашдаа Эдийн засгийн байнгын хорооны хүрээнд хамаарч байгаа бол энэ дээр яах талаараа бид ярилцах нь зөв гэж бодож байна. Баярлалаа.

**О.Батнайрамдал:** М.Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя.

Цэцийн дүгнэлтээс өөр асуудлаар өөрчлөлт хийж болох уу гэж асуусан. Энэ бол хуулийн хүрээнд боломжгүй. Яг цэцээс ирсэн ийм ийм зүйл, заалтаар гэсэн зүйл, заалтын дагуу л өөрчлөлт орно гэж хариулт өгье.

Тодруулах юм уу? М.Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. М.Энхцэцэг гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг.

**М.Энхцэцэг:** Мэргэжлийн холбоодын асуудалтай холбоотойгоор цэцийн дүгнэлт гарсан байна л даа.

Түүнтэй холбоотойгоор энэ хууль дээр өөрчлөлт оруулах тэр ажлыг Эдийн засгийн байнгын хороо зохион байгуулж хэрэгжүүлэх хуулийн хугацаатай юм байна.

Сая хариулж байна. Зөвхөн цэц дээр хэлэлцэгдсэн асуудлаар л өөрчлөлт оруулна гэж.

Тэгэхээр миний хэлэх гээд байгаа санаа юу вэ гэхээр ер нь энэ мэргэжлийн холбоод дээр бид энэ хууль дээр онцгойлон анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай болсон юм байна гэж харж байгаа.

Яагаад гэхээр ер нь борооны дараах мөөг гэж ярьдаг. Тийм ээ. Яг түүнтэй адилхан маш их хэмжээний, зөвхөн ганцхан үгийн зөрүүтэй ийм мэргэжлийн холбоод маш их байгуулагдсан юм билээ.

Тэгээд яг тэр мэргэжлийн холбоод маань үнэхээр тэр холбооныхоо цаана байгаа компаниудын эрх ашгийг хөндөж, эрх ашгийг хамгаалж чадаж байна уу гэхээр бас эргэлзээтэй.

Хоёрдугаар асуудал болохоор бараг юу гэдэг юм нэг хүн хармаандаа бараг 10-аад Төрийн бус байгууллага ч юм уу, мэргэжлийн холбоодын тамгыг хармаалчихсан нэг хүний компани аятай явж байдаг юм билээ.

Тэгээд компаниа тэр мэргэжлийн холбоодоор ашгийн бус байгууллага гэдэг утгаараа бараг компаниас илүү хэмжээний хөрөнгө, санхүүгийн асуудал түүгээр гүйлгээ явагдаж байдаг.

Тэгэхээр үүнийг аягүй сайн цэгцлэх ёстой юм билээ. Компаниуд нь болохоор хөөрхий татвараа төлөөд л тодорхой хэмжээний ажил хийгээд байдаг. Гэтэл мэргэжлийн холбоод болохоор ашгийн бус гэдгээрээ маш их хэмжээний хөрөнгө, санхүүгийн асуудал түүгээр явж байдаг юм билээ.

Тэгэхээр үүнийг цэгцлэх чиглэл рүү энэ хуулийг сайжруулах байдлаар ажлын хэсэг байгуулаад ажиллах нь зүйтэй байх гэсэн саналыг дэвшүүлж байна.

**Р.Сэддорж:** Гишүүдийг дуудаарай. Гишүүд санал хураалтад орно.

Миний хувьд нэг санал байна.

Ер нь Төрийн бус байгууллагын хуульд би шүүмжлэлтэй ханддаг. Төрийн бус байгууллагын хууль манайх шиг орныг задалж магадгүй тийм хууль. Жишээ нь, манайд чинь хүн оролцдог холбоо болгон бараг 2-оос дээш болсон гэж болно. Спортын холбоод байна. Тийм ээ. Дандаа хоорондоо маргадаг. Ялангуяа тэр үндэсний спортын холбоод хоорондоо маргах нь энэ үндэстэнд маш аюултай, хохиролтой. Тийм ээ.

Тэгэхээр Шагайн холбоо, Ссурын холбоо л нэг гайгүй байдаг байх.

Тэгээд хүн оролцсон холбоо болгон ингэж хоёр, гурав хуваагдаж хоорондоо маргалдаж, бүр наадмаа хийх үү, хийхгүй юу гэдэг дээр очиж маргалддаг ийм хэцүү холбоод байдаг.

Тэгээд Төрийн бус байгууллагын хууль их анхааралтай, болгоомжтой хандахгүй бол улс үндэстнийг задлах, бутаргах, хооронд нь эвдрэлцүүлэх ийм агуулга зүйл, заалт дээр нь байхыг үгүйсгэхгүй. Ийм учраас энэ цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй гэж үзэж байна.

Тэгээд мэдээж төр бүх юманд оролцож, бүх юманд хараа хяналтаа тавина гэж байхгүй. Энэ мэргэжлийн холбоод хэрэгтэй.

Тэгэхээр энэ холбоодыг цэгцлэх гээд хуулиа улам сайжруулж байгаа л хэрэг гэж үзэж байна.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Саналын томъёолол.

**1.** Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**2.** Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**3.** Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**4.** Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад “хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулна.

О.Батнайрамдал гишүүн өөрөө итгэмжлэгдсэн төлөөлөгч учраас болохгүй юм байна.

Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг танилцуулна.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

---

### **Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл**

*/Ажлын хэсэг байгуулах тухай/*

---

Хэлэлцэх асуудал. Хоёр.Санхүүгийн хоршооны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах талаар “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

“Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт Монгол Улсын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Санхүүгийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

**Ажлын хэсгийн ахлагч:**

Л.Соронзонболд

Улсын Их Хурлын гишүүн

---

**Ажлын хэсгийн гишүүд:**

|               |                        |
|---------------|------------------------|
| Р.Батболд     | Улсын Их Хурлын гишүүн |
| Н.Батсүмбэрэл | Улсын Их Хурлын гишүүн |
| М.Мандхай     | Улсын Их Хурлын гишүүн |
| Г.Очирбат     | Улсын Их Хурлын гишүүн |
| А.Ундраа      | Улсын Их Хурлын гишүүн |
| Г.Уянгахишиг  | Улсын Их Хурлын гишүүн |
| П.Батчимэг    | Улсын Их Хурлын гишүүн |
| Ц.Баатархүү   | Улсын Их Хурлын гишүүн |

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг Ажлын хэсэгт зөвшөөрсүгэй.

Эдийн засгийн байнгын хороо.

Гишүүд ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье.

М.Энхцэцэг гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг.

**М.Энхцэцэг:** Санхүүгийн зохицуулах хорооны ажлын хэсэгт оръё гэсэн саналтай байна.

**Р.Сэддорж:** М.Энхцэцэг гишүүний саналаар М.Энхцэцэг гишүүнийг ажлын хэсэгт нэмээд. Одоо хуулиараа 10 хүртэлх гишүүнтэй байх хуультай.

Тийм учраас 10 гишүүн болж байна.

Ажлын хэсгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, ажлын хэсгийн гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Н.Батсүмбэрэл, М.Мандхай, Г.Очирбат, А.Ундраа, Г.Уянгахишиг, П.Батчимэг, Ц.Баатархүү, М.Энхцэцэг нарын гишүүд орж байна.

Ингээд гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Саналын томьёолол.

“Ажлын хэсэг байгуулах тухай”. Санхүүгийн хоршооны тухай хуулийн ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа. /алх цохив/

---

### **Гурав.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан**

---

Хэлэлцэх асуудал. Гурав.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг оруулъя.

Хууль, тогтоолоор чиг үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтэд хийсэн дүн шинжилгээний тайланг Та бүхэнд тараасан байгаа.

Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр Засгийн газрын мэдээллийг танилцуулна.

Сайдын микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан хууль тогтоомж тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журмын 6-д заасны дагуу цахим системд хяналтад байгаа Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хамаарах 75 шийдвэрийн 508 заалтын биелэлтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг танилцуулж байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санд ирүүлсэн тайлан мэдээллийн их өгөгдлийн дата баазыг ашиглаж хийсэн бөгөөд анхан шатын нэгжээс шат дараалсан үнэлгээний тайланд нэгтгэсэн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

Энэ үйл явцад яам, агентлаг, орон нутгийн төлөөллийг оролцуулснаас гадна Канадын Мерит төсөл, ЮНИСЕФ, Удирдлагын академийн зөвлөхүүдийн арга зүйн дэмжлэг, зөвлөмж, саналыг тусган ажилласан нь анх удаа бүх шатны оролцоог хангасан арга хэмжээ боллоо.

---

Мөн ажлын бүтээмж, үр дүнг нэмэгдүүлэхэд технологийн дэвшлийг ашиглаж, тус Байнгын хороонд хамаарах шийдвэрүүдийн биелэлтэд хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийж үзлээ.

2025 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 75 шийдвэрийн 508 заалтыг яам, агентлаг, аймаг, нийслэлд хэрэгжүүлж ажилласан 71 хувьтай байна.

- ▶ Нийт 245 заалт хэрэгжсэн.
- ▶ 166 заалт хэрэгжих шатанд байна.
  
- Үүнээс удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай 70 заалт, хэрэгжээгүй 30 заалт байгаагаас бүгд удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалсан байна.
  
- Хугацаатай өгөгдсөн, оны төгсгөлд гарсан буюу хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 10 заалт байна.
  
- Мөн хэрэгжүүлэх хугацаа, чиг үүрэг тодорхойгүй, зардал, санхүүгийн эх үүсвэр, хийх ажил, зорилго тодорхойгүй, хэмжигдэхүйц биш байдлаас үүдсэн 57 шийдвэр хэрэгжих боломжгүйгээр дүгнэгдсэн байна.

Энэ нь ихэвчлэн Улсын Их Хурлын харьяа Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны чиг үүрэгт хамаарах заалтууд байна.

2025 оны жилийн эцсийн хяналт, шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн бодит шалтгааны улмаас–

- ▶ хэрэгжих боломжгүй болсон,
- ▶ цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон,
- ▶ тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан,
- ▶ тухайн шийдвэр хүчингүй болсон–

-зэрэг шалтгаанаар 245 заалтыг Засгийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сангийн хяналтаас хасах үндэслэлтэй гэж үзэж Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Тайлант онд хэрэгжээгүй шийдвэрүүд нь төрийн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт хангалтгүйгээс шалтгаалсан гэж дүгнэгдэж байна.

Тухайлбал, төрийн байгууллагын түвшинд–

- ▷ хариуцлагын тогтолцоо хангалттай бүрдээгүй,
- ▷ салбар хоорондын ажлын уялдаа сул,
- ▷ олон удаагийн бүтцийн өөрчлөлт хийгдсэн,
- ▷ төсөв, хөрөнгө оруулалтын эрэмбэ дараалал хангалтгүй,

➤ бодлогын болон хүний нөөцийн тогтворгүй байдал-

-зэрэг нь хууль тогтоомжийн биелэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн 2025 оны жилийн эцсийн тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авахыг даалгасан. Үүнд:

- хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлж, салбар хоорондын уялдааг ханган, бодитой үр дүнтэй хэрэгжүүлэх;
- салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, иргэдийн ахуй амьдрал болон салбарын хөгжлийн үзүүлэлтэд хэрхэн нөлөөлж буйг үнэлж тооцож ажиллах;
- хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төслийг боловсруулахдаа зохицуулалт, утга агуулгын хувьд давхардал, хийдэл, зөрчилтэй шийдвэр гаргахгүй байх, санхүүгийн эх үүсвэрийг тусгах, хэрэгжилтийг хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт хэрэгжихүйц байхад анхаарах;
- дижитал хяналт, их өгөгдөлд суурилсан үнэлгээ хийх, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг бодит цагт хянах, ил тод болгох чиглэлээр цахим шинэчлэл хийх санал боловсруулж танилцуулах;
- хууль тогтоомжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад даалгасан.

Цаашид Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэлд бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлтийн талаар баримтлах бодлого буюу Улсын Их Хурлын 1996 оны 138 дугаар тогтоолыг эргэн харах, шинэчлэх, сайжруулах үндэслэл бий болсныг харуулж байгааг дурдах нь зүйтэй байна.

Хууль тогтоомжийн биелэлттэй холбоотойгоор Улсын Их Хурлын түвшинд анхаарах дараах асуудал байна.

➤ Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог, сонгогддог байгууллагуудад үүрэг даалгавар болгосон шийдвэрийн хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах үйл ажиллагааг гүйцэтгэх засаглалын байгууллагын түвшинд уялдуулах, нэгдсэн байдлаар тайлагнах боломжийг бүрдүүлэх.

► Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрийн талаар нэгдсэн бүртгэлийн систем үүсгэж, Засгийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сантай уялдуулах.

► Гарч байгаа шийдвэрийг шуурхай дамжуулах, хяналтад авах, Улсын Их Хурлын байнгын хороо гишүүдийн түвшинд шийдвэрийн хэрэгжилтийн явцыг цахим систем ашиглан танилцах боломжтой болох.

► Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил болон тухайн жилд бүрэн хэрэгжсэн болон бусад шалтгаанаар хяналтаас хасуулах шийдвэр заалтын талаар Засгийн газартай тогтмол харилцаж ажиллах.

► Хууль тогтоомж, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хороодын шийдвэр, Засгийн газрын бодлогын баримт бичигт заасан зарим заалт агуулгын хувьд давхцах хуулиар ногдуулсан чиг үүргийг дахин тогтоол хэлбэрээр албажуулах зэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх.

► Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16.1.1 Улсын Их Хурлаас Засгийн газар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаас бусад Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ээлжит чуулган эхлэхээс 15 хоногийн өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ гэж заасан нь цаг хугацааны хувьд үр дүнд суурилсан хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд хангалтгүй байгаа тул хугацааг уян хатан байдлаар зохицуулах зэрэг болно.

Тус Байнгын хороонд хамаарах шийдвэрүүдийн биелэлтэд анх удаа хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийсэн бөгөөд нийт заалтын

- 0.6 хувь нь хуулиар ногдуулсан чиг үүргийг дахин үргэжүүлсэн заалт,
- 27.7 хувь нь тогтоолын хэрэгжилтийг давтан баталгаажуулсан заалт,
- 7.7 хувь нь бодлогын баримт бичигтэй агуулгын огтлолцол бүхий заалт тус тус эзэлж байна.

Цаашид Улсын Их Хурлын холбогдох бүтцийн нэгжтэй хамтран хиймэл оюун ухаан ашиглан дүн шинжилгээ хийх ажлыг улам боловсронгуй болгох, Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрийн биелэлт, үр нөлөө, хяналтыг сайжруулахаар зорьж байна.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хамаарах хууль, тогтоолын биелэлтийн 2025 оны жилийн эцсийн хяналт, шинжилгээ, үнэлгээний мэдээллийг Та бүхэнд хавсаргаж тараасан болно. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Ажлын хэсгийг танилцуулъя.

Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Ч.Бат-Эрдэнэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Х.Оюунцэцэг Шадар сайдын ажлын албаны зөвлөх, Л.Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга,

Б.Анар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Н.Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ш.Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Х.Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Болор-Эрдэнэ Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, М.Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ц.Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлогын газрын дарга, Б.Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, В.Түвшинжаргал Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Ц.Өнөрнасан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, А.Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Ц.Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, Ц.Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Ү.Ганболд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, Л.Наранчимэг “Эрдэнэс Монгол” компанийн Эрсдэлийн удирдлагын газрын дарга, Д.Эрдэнэбаяр Бүсчилсэн хөгжлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал.

Засгийн газрын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье. О.Батнайрамдал гишүүн.

**О.Батнайрамдал:** Бүхэндээ энэ өглөөний мэнд хүргэе.

Магадгүй Улсын Их Хурлын тухайн жилдээ хамгийн чухал хэлэлцэх ёстой асуудлын нэг өнөөдөр орж ирж байна л даа.

Улсын Их Хурлаас гаргасан хууль, тогтоол, шийдвэрүүдийн биелэлт хэрхэн хангагдсан бэ гэдгийг өнөөдөр бид ярилцах юм байна.

Нэг ёсондоо Улсын Их Хурлаас гаргасан хууль, тогтоолыг гүйцэтгэх засаглал хэрхэн хэрэгжүүлж, ямар хяналт шалгалт хийлгэж, ямар дүн тавьж байгаа вэ гэдэг асуудлыг өнөөдөр бид ярилцах гэж байна.

Нэг ёсондоо улс төрийн хариуцлага хүлээж сайд болсон хүмүүс хэрхэн ажлаа хийсэн бэ гэдгийг дүгнэсэн тайлан байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хяналт шалгалт, Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг тайлагнах үндсэн субъект өөрөө улс төрийн албан тушаалтнууд шүү. Нэг ёсондоо яг салбар хариуцаж байгаа сайд нар. Томилогдох болохоороо шөнөжингөө хуралдаж байгаад томилогддог шүү дээ.

Тэгээд ажлаа тайлагнаад, хийсэн ажлаа хамгаалъя гэхээр өөрсдөө хэдэн төрийн албан хаагчдаа явуулчхаж болохгүй байхгүй юу.

Өнөөдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд гэсэн ганцхан хүн л байна. Бусад сайд нар хаана байгаа юм. Яах вэ, Засгийн газар хуралдаж байгаагаа ойлгож байна.

Тэгээд гурав дахь өдөр хуралдаж байгаа юм чинь гээд бид энэ асуудлыг Төрийн нарийнуудаа урдаа тавиад өнгөрөөнө гэж болохгүй. Яагаад гэх юм энэ асуудлын агуулга нь өөрөө аягүй чухал байхгүй юу.

Бид энд хууль батлаад л байдаг, Улсын Их Хурлын тогтоол гаргаад л байдаг. Тэр нь үнэхээр хэрэгжиж байгаа юм уу, үгүй юм уу. Энэ хэрэгжилт дээрээ 80, 90 хувь гээд л тавьсан байна.

Үүнийгээ яг улс төрийн хариуцлага хүлээж байгаа сайд нар өөрсдөө ирж тайлагнах үүрэгтэй юм.

Тэгэхээр хэдэн төрийн нарийнаа явуулчхаад төрийн албан хаагчид өмнөөс нь улс төрийн албан тушаалтны хүлээсэн үүргийг өнөөдөр хариулж болохгүй байхгүй юу.

Тийм учраас сайд нар иртэл өнөөдрийн энэ чухал асуудлыг би хойшлуулах саналыг гаргаж байна. Хуулийн хугацаагаа яагаад та нар тэгвэл ингэж оройтуулж оруулж ирсэн юм. Үүнийг Эдийн засгийн байнгын хорооны ажлын албанаас хариулъя. Хуулийн хугацаа юу?

Гэхдээ сайд нар өөрсдөө байж энэ дээр хариулах ёстой юм.

Тийм учраас үүнийг хойшлуулах горимын санал гаргаж байна. Үгүй, та нар тэгээд өөрсдөө л шийдээрэй. Би горимын санал гаргая.

**Р.Сэддорж:** Гишүүдийн саналыг сонслоо.

О.Батнайрамдал гишүүний гаргасан горимын саналыг санал хураалтаар шийднэ.

Ингээд гишүүдийн гарч байгаа санал зүйтэй шүү дээ. Одоо ингээд гурав дахь өдрийн Засгийн газрын хуралдаантай давхцуулж хамгийн чухал Байнгын хорооны энэ их тайланг ингэж хэлэлцэж байдаг, давхцуулж цагийг нь тавьж байдаг. Энэ зохион байгуулалтын алдаа.

Сайдуудыг шаардаж байгаа нь л гишүүдийн зөв зүйтэй санал. Дээрээс нь энэ хуулийн хугацаа 3 сарын 18-нд ирсэн байна. Байнгын хороонд.

Тэгэхээр 4 сарын 18-ны дотор хэлэлцэх юм байна. 3 хоног байгаа юм байна.

Ингээд О.Батнайрамдал гишүүний гаргасан хойшлуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Даргын дэргэдэх зөвлөл дээр л шийдсэн асуудал л даа. Яг хэзээ орох барих, өдөр хоног нь. Өчигдөр байж болох л байлаа.

Тэгээд заавал ингэж гурав дахь өдөр тавьсан маргаан дагуулж байна.

Мөн цэцийн дүгнэлттэй холбоотойгоор өнөөдөр хуралдааныг тавьсан. Ингээд үргэлжлүүлэе. Саналаа татаж авлаа. Ажлын хэсгийг танилцууллаа.

Засгийн газрын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье.

Б.Пунсалмаа гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг.

**М.Энхцэцэг:** Улсын Их Хурлаас гарсан хууль тогтоомжийн шийдвэрийн биелэлтийг танилцуулж байгаа Засгийн газрынхандаа баярлалаа.

Тэгэхээр эрчим хүчнийхээ салбартай холбоотой би хэд хэдэн асуултуудыг асууя гэж бодож байна. Эрчим хүчний яамны хуулиар хүлээсэн үндсэн үүрэг бол энэ салбарын хууль, дүрэм, журам, стандартыг боловсруулж, сайжруулж явах ёстой.

Тэгэхээр миний харж байгаагаар Эрчим хүчний яамны энэ үүргээ биелүүлж байгаа байдал төдийлөн хангалттай биш байна гэж хардаг.

► **Нэгдүгээр асуудал.** Орчин үед техник, технологи маш их шинэчлэгдэж байна.

- Гэтэл “техник ашиглалтын дүрэм” гээд маш том дүрэм байдаг. Тэр дүрмээ одоо хүртэл шинэчлээгүй.

Орчин үед тэр нарны станц дээр жишээ нь заавал 24 цагаар хүн суух шаардлага байхгүй. Гэтэл хуучин дүрэм дээр нь заавал 24/7-гоор хүн суулга гээд бүр заасан байдаг.

Тийм учраас заавал хүн суулгахаас аргагүй болоод ингээд ашиглалтын зардлыг нэмэгдүүлж байгаа. Энэ бол зүгээр наад захын жишээ. Нөгөө дүрмээ шинэчилдэггүй.

- ▶ **Хоёрдугаар асуудал.** Та бүхэн мэднэ. Өнөөдөр системийн тогтворжилтын асуудал маш хүнд. Сэргээгдэх эрчим хүчийг холбох тусам тогтворжилт хүндэрдэг.

Тэгэхээр энэ тогтворжилтыг хангахад маш чухал үндсэн бичиг баримт бол “Grid Code” буюу “Сүлжээний дүрэм”.

- Одоо хүртэл “сүлжээний дүрэм”-ийг шинэчлээгүй.

Тэр дүрэм дээр сэргээгдэх эрчим хүч, сүлжээний тогтворжилтыг хангахын тулд ямар техникийн шаардлагыг хангаж байх ёстой гэдэг юм бас байхгүй.

- ▶ **Гуравдугаар асуудал.** Та бүхэн мэднэ. Сүүлийн үед цахилгаанаас үүдэлтэй гал түймэр маш их гарч байгаа. Хүүхэд тогонд цохиулж үхэж байна. Маш их хэмжээний гал түймэр гарч, аж ахуйн нэгжүүд хөрөнгө санхүүгээрээ хохирч байна.

- Үүнтэй холбоотой “стандарт” байхгүй. Шинэчлэгддэггүй.

- Эрчим хүчний яам нь хариуцаад байгаа юм уу?
- Барилгын яам нь хариуцаад байгаа юм уу?

Ерөөсөө шинэчилдэггүй.

Тэгэхээр энэ асуудал дээр чухам Та бүхэн ямар ажлуудыг хийж байна? Энэ бол Та бүхний хуулийн өмнө хүлээсэн олон үүргүүдийн чинь нэг үүрэг.

Хоёрдугаар асуудал. Та бүхэн мэдэж байгаа. Улсын Их Хурлаас Сэргээгдэх эрчим хүчийг эрчимжүүлэх тогтоол батлагдсан. Энэ хүрээнд сэргээгдэхийн эрчимжүүлэх том том ажлууд хийгдэх гэж байна.

Гэхдээ эрчим хүчний салбарын эдийн засгийг хямруулаад байгаа, өр нэмэгдүүлээд байгаа нэг том асуудал бол мэдээж өндөр тарифтай сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд.

Цаашдаа бид сэргээгдэхийн тэр анх орж ирж байгаа том эх үүсвэрүүдийн явал тарифыг бууруулах вэ, явал өрсөлдөөний зарчмаар явуулах вэ гэдэг. Гэтэл Та бүхэн. Би хугацаагаа нэмээд авъя.

**Р.Сэддорж:** М.Энхцэцэг гишүүн 1 минут.

**М.Энхцэцэг:** Тэгэхээр энэ тогтоолтой холбоотой сайхан олон төслүүд явах гэж байгаа нь сайн хэрэг.

Хамгийн гол нь явал тэр тарифыг нь буулгах вэ гэдэг дээр зөв зарчмаараа сэргээгдэх эрчим хүчнийхээ тухай хуулиар тэр өрсөлдөөнийг богино хугацаанд

хялбар байдлаар зарлаад, тэр үнэ тарифыг 5, 6 цент рүү оруулах арга хэмжээг авах ёстой.

Тэгэхгүй бол одоо сүүлийн үед дэлхийд байхгүй өөрөө цэнэглэдэг батарей гэсэн нэг ийм хэллэг гаргаж ирээд тэгээд бараг 10 центээр, 9 центээр. Одоо 10 центээр, 9 центээр сэргээгдэх хэрвээ эрчим хүчний салбар тоологдох юм бол эрчим хүчний салбар өр ширэндээ баригдаж, эдийн засгийн хувьд бүр хямрал нь дээд цэгтээ хүрнэ.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн ямар байдлаар хуулиа хэрэгжүүлж ажиллах гэж байгаа вэ? Энэ дээрээ анхаараач ээ гэж бүр онцгойлон хэлмээр байна.

Яагаад гэхээр Та бүхэн мэднэ. Айл өрхүүд 285 төгрөгөөр, ялангуяа түгээх сүлжээнд холбогдож байгаа сэргээгдэх бол 285 төгрөгөөр сүлжээнд холбогдъё гээд байгаа.

Тэр хүмүүсийг болохгүй гэсэн хэрнээ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт индэр дээр. тийм. Өөрийгөө танилцуулаад.

**Б.Ерэн-Өлзий:** Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий.

М.Энхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Эрчим хүчний салбарт хэрэглэгдэж байгаа “аюулгүй ажиллагааны дүрэм”, “техник ашиглалтын дүрэм” гээд холбогдох техникийн үндсэн баримт бичгүүд байгаа.

Үүн дээр Эрчим хүчний яамны харьяа Эдийн засгийн хүрээлэн тухай бүр 3-аас 4 жилийн давтамжтай энэ дүрэмд холбогдох өөрчлөлт оруулах асуудал дээр баг бүрдүүлж, суурь судалгааны ажлууд хийж ажиллаж байгаа.

Хамгийн сүүлд өнгөрсөн 2022 оны үед энэ техник ашиглалтын зарим дүрмүүдэд өөрчлөлт оруулсан.

Ер нь “системийн нэгдсэн сүлжээний дүрэм”-ийг Диспетчерийн үндэсний төв хариуцаж, дунджаар 2 жилд энэ дээр оруулах нэмэлт, өөрчлөлтүүдээ оруулаад Эрчим хүчний сайдаар батлуулаад явж байгаа.

М.Энхцэцэг гишүүний хэлж байгаа энэ бол шинээр үүсэж байгаа, хөгжиж байгаа технологиуд хурдацтай хөгжиж гарч ирж байна.

Үүний нэг жишээ бол “Батарей хуримтлуурын төсөл” юм. Үүнтэй холбоотой дүрэм журам, техник ашиглалтын дүрмүүдэд шинэ бий болж байгаа технологиудыг бүрэн тусгах асуудал тодорхой хэмжээнд бүрэн тусаагүй. Цаг хугацааны хүлээлтэд байгаа, судалгааны шатад байгаа асуудлууд байна.

Хэрэглэгчийн түвшинд барилгын стандарт дээр бага насны хүүхдүүд тогонд цохиулах ийм асуудал гардаг. Бидний гол харьяа байгууллагуудтай хийж байгаа дүгнэлтээр ерөөсөө одоо байгаа стандартыгаа бүрэн мөрдүүлэх, түүнд нь техникийн хяналтыг тавих хамгийн чухал байна.

Стандартууд байна. Үүнийгээ яаж мөрдүүлж хяналт тавьж ажиллах вэ гэдэг дээр гол анхаарлаа хандуулах нь хамгийн чухал байгаа.

Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс үйлдвэрлэж байгаа эрчим хүчний үнэ тарифыг буулгахад бидний гол гарц бол өрсөлдөөн үүсгэж олон улсын нээлттэй тендер шалгаруулалт буюу аукционоор сэргээгдэх эрчим хүчнээс цахилгаан үйлдвэрлэх төслүүдийг хэрэгжүүлэх арга зам байгаа.

Энэ хүрээнд бид Азийн хөгжлийн банктэй хамтраад Монгол Улсын баруун зүүн бүсэд 7 байршилд нийлбэр хүчин чадал нь 105 мегаваттын нарны эх үүсвэрийг батарей хуримтлуурын хамт олон улсын өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар барьж байгуулах гээд суурь судалгааны ажлууд хийгдээд одоо дуусаж байна.

- Энэ оны 7 дугаар сард анхны “нарны аукцион”-ыг зарлана гэж байгаа.

Салхины тухайд Дэлхийн банктэй хамтраад Дундговь аймгийн Мандалговь орчимд 100 мегаваттын салхины авокационыг зохион байгуулна.

Үүний бэлтгэл ажил, ТЭЗҮ, салхины хэмжилтүүд нь нэг жилийн хугацаанд хийгдээд дуусаж байна.

- Энэ оны 6 сард анхны “салхины олон улсын аукцион”-ыг зарлана гээд төлөвлөөд явж байгаа.

Батарей хуримтлуурын төслүүдийн тухайд өртөг хямдарч байгаатай холбогдуулаад хувийн хэвшлийн зүгээс батарейны төсөл хэрэгжүүлье гэсэн санал, санаачилга Эрчим хүчний яаманд их ирж байгаа.

Тэгэхдээ манай эрчим хүчний системийн өөрийнх нь онцлогоос шалтгаалаад батарей хуримтлуурын төслүүдийг шингээх хязгаар байгаа.

Тэр болгон тэр батарей хуримтлуурын төслүүдийг хямдралтай үнээр шөнийн цагаар цэнэглээд татаастай үнээр оройн цагаар аваад байхад хүндрэлтэй.

Тийм болохоор зарим батарейны төсөл хэрэгжүүлье гэж байгаа хувийн компаниудад системээс хямдралтай үнээр цэнэглэх... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулъя.

**Б.Ерэн-Өлзий:** Системээс хямдралтай үнээр цэнэглэх хүндрэлтэй.

Салбар өөрөө үнэ тариф нь нэмэгдэхгүй хязгаартай, алдагдалтай нөхцөлд байж байгаа энэ нөхцөлд системээс хямдралтай үнээр, алдагдалтай үнээр цэнэглэж чадахгүй.

Та нар батарейгаа цэнэглэх эрчим хүчний эх үүсвэрээ өөрсдөө бариад тэгээд тухайн батарейнаасаа орой оргил ачааллын үед яг хэрэгтэй үед нь нийлүүлээч ээ. Энэ үед нь 10 центээр худалдаж авъя гэсэн агуулгаар Сайдын зөвлөлийн шийдвэр гаргаад энэ дээр зарим хувийн хөрөнгө оруулагчидтай хамтраад ажиллаж байгаа.

Тэгэхдээ одоогоор нэг компани тусгай зөвшөөрлөө яг энэ чиглэлд авсан байгаа. Яг хэрэгжсэн төсөл байхгүй байна.

**Р.Сэддорж:** М.Энхцэцэг гишүүн тодруулж асууя.

**М.Энхцэцэг:** Тэгэхээр тодруулж асууя гэж бодож байна.

Тэр батарейн төсөл дээр Та бүхэн мэдэж байгаа. Мэдээж батарей байна уу, цаанаа батарейгаа цэнэглэдэг нарны станцтай байна уу, тэр тэгээд л сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр.

Тэгэхээр энэ бол Сэргээгдэх эрчим хүчнийхээ тухай хуулиар өрсөлдөөн зарлагдаад, тэр үнэ тариф нь буурах ёстой.

Түүнээс биш зүгээр нэг сайдын хурлын тэмдэглэлээр 10 цент гэж зөвшөөрөөд тийм эх үүсвэрийг оруулах юм бол Та бүхэн хууль зөрчинө. Эрчим хүчнийхээ салбарыг эдийн засгийн хувьд хямруулна.

Тийм учраас энэ дээр онцгойлон анхаараач. Зөвхөн нэг төсөл явж байгаа гэж байна. Тэгэхдээ цаана чинь маш олон төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл нь байгуулагдсан. Тэр “Пи Пи Эй”, ТЭЗҮ нь байгуулагдсан гээд ингээд тэр нь цаашаа зарагдаад явж байгаа.

Тэгэхээр ингэж хөрөнгө оруулагчдыг хохироож болохгүй гэж харж байна.

Дээрээс нь тэр “техник ашиглалтын дүрэм” **Grid Code** чинь хамгийн сүүлд хэзээ шинэчлэгдсэн юм? Хамгийн сүүлд 2023 оноос хойш шинэчлэгдээгүй ч билүү... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал.

**О.Батнайрамдал:** Өнөөдөр магадгүй 2026 оны хамгийн чухалд нэг зүйлийг бид хэлэлцэж байгаа байхгүй юу.

— Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоол хэрхэн биелсэн бэ?

— Хэрхэн хэрэгжсэн бэ?

Яг үүнийг ярих болсон чинь энэ танхим дотор нэг ч сайд алга. Үүнийг хэрэгжүүлнэ гэж улс төрийн албан тушаал авсан нэг ч хүн алга. Төрийн нарийнууд байна. Төрийн нарийнууд төрийн албан хаагчид шүү дээ. Хариуцлага хүмүүс хүлээх хүмүүс нь биш байхгүй юу.

Тэгэхээр ер нь бидний алдаа л энэ байна л даа. Монгол Улс хууль багадсандаа биш тэр хэдэн баталсан хууль, тогтоол нь хэрэгжсэн үү, хэрэгжилтэд хяналт тавьсан уу гэдэг л асуудал шүү дээ.

Тэгээд яг үүнийг нь жилд ганцхан удаа ярьдаг энэ үе дээрээ нэг ч сайд байхгүй. Бидний байж байгаа царай ийм л байна.

Тэгээд дээрээс нь энэ биелэлтийн тайлан бол яг үнэнийг хэлэхэд би өөрийнхөө стандартаар хэлье. Надад дэндүү гологдож байна. Нээрээ арай ч дээ л гэж хэлмээр байна. Ийм тайлангаар бид бүхэл бүтэн Улсын Их Хурлын институцийн баталсан хууль, тогтоолыг хэрэгжилтийг нь хянаж байгаад харамсаж байна.

Өнөөдөр энэ хүснэгт 3 салбарын үнэлгээ яам тус бүрээр.

- Өнөөдөр Боловсролын яам өөрийгөө 90 хувьтай гээд үнэлсэн байна.
- Эрчим хүчний яам чинь 100 хувь гэж үнэлсэн байна шүү.

Өнөөдөр тэгээд энэ яамдууд ажлаа 100 хувь хийчхээд тэгээд өнөөдөр бид ард түмний амьдрал 90, 100 хувиар дээшилсэн юм уу?

Ингэж өөрсдийгөө хуурсан байдлаар явмааргүй байна. Ядаж албан тушаал авсан бол тэр албан тушаалаа аваад асуудлаа хэрхэн шийдсэн бэ гэдэг биелэлт дээр сайд нар өөрсдөө ирээд хариулах ёстой гэж бодож байна.

Маш тодорхой хэдэн асуулт асууя. Одоо Төрийн нарийнаас л асуух юм шиг байна.

Энэ Улсын Их Хурлын тогтоолын биелэлт дээр Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний биелэлт нь яасан юм бэ? Оюу Толгойн 3 тогтоол бүгдээрээ байна. 2019, 2021 оны тогтоолын 7 асуудлуудын 2 нь хэрэгжсэн гэж байгаа. Яг юуг хэрэгжсэн гэж байгаа юм?

“Хэрэгжсэн” гэдэг үг хэрэглэгдэж байна л даа. “Хэрэгжсэн” гэдэг нь тэр асуудлаар нэг хурал хийхээр хэрэгжсэн гэж тооцож байгаа юм биш биз дээ?

Асуудал болгон дээр “хэрэгжсэн” гэдэг дээр дүгнэлт, тайлбарууд ингээд нэмэлтээр байх хэрэгтэй байхгүй юу. Тийм болохоор энэ тайлангаа цаашаагаа

юу нь хэрэгжсэн гэж үзээд байгаа юм, хэрэгжээгүй юм гэдэг нь маш ойлгомжгүй байгаад байна л даа.

Тэгэхээр бид энд хууль, тогтоол батлаад л байдаг.

- Тэр нь хамгийн гол нь хэрэгжсэн үү?
- Хэрэгжихдээ яг юу нь хэрэгжээд, яг юун дээрээ гацаад байгаа юм?
- Яг юу нь явахгүй болохгүй байгаа юм?

Тэгэхээр энэ талаараа ингэж ярилцах хэрэгтэй юм л даа.

Дээрээс нь Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай тогтоол бүгд хэрэгжсэн гэж байх юм. Энэ яг юу хэрэгжсэн болоод хэрэгжсэн гэж тавьж байгаа юм? Энд тодорхой хариулт авъя. Энэ дээр.

**Р.Сэддорж:** Индрийн микрофон. Хариулт. Өөрийгөө танилцуулаад.

**Ш.Мөнхцэрэн:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Ш.Мөнхцэрэн байна.

Тэгээд яг энэ асуудал дээр нэмээд манай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам хариулах байх.

Улсын Их Хурлаас Оюу Толгойтой холбоотой 3 тогтоол гарсан байгаа.

- 2019 оны 92,
- 2021 оны 103,
- 2025 оны 120 дугаар тогтоол гарсан.

Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газар дээр үндсэндээ яг өнөөдрийн байдлаар 5 ажлын хэсэг ажиллаж байгаа.

Мөн айлын талтай хэлэлцээ хийх 3 баг ажиллаж байгаа.

Үндсэндээ 103 болон 120 дугаар тогтоолын хэрэгжилтийн давхцалыг бид гаргаад одоо 120 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд хэд хэдэн өмнөх байгуулсан ажлын хэсгүүдийнхээ удирдамж дээр нэлээн чиглэлүүдийг өөрчилж оруулж өгсөн байгаа.

103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд нэгдүгээрт зарим нь өмнө нь хийгдсэн. 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 92 дугаар тогтоолоор Оюу Толгойн төслийн гадаад хөрөнгө оруулагчтай хийсэн хэлэлцээрийн хүрээнд гадаад хөрөнгө оруулагчаас ирүүлсэн саналыг харгалзаж хууль тогтоомжид Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд Засгийн газарт даалгасан нэг заалт байгаа. Энэ нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд

хуримтлагдаад байгаа нийт 2.3 тэрбум долларын өрийг 100 хувь тэглэх гэсэн асуудал байсан.

Үүнийг үндсэндээ Засгийн газар дээр төрийн эзэмшлийн 34 хувьд ногдох “Эрдэнэс Оюу Толгой” компани нь “Оюу Толгой” компаниас төлөгдөх энэ 2.3 тэрбум долларын өрийг 100 хувь тэглэж, тогтоолын хэрэгжилтийг хангасан гэж үзэж байгаа.

Хоёрдугаарт нь, 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан “Далд уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөө”, мөн “Далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө”-г хуульд нийцүүлэн цуцалж хүчингүй болгох гэсэн нэг заалт байгаа.

Энэ хүрээнд “Эрдэнэс Оюу Толгой” компаниас 2022 оны 8 дугаар сарын 16-ны өдөр, мөн “Эрдэнэс Монгол” компаниас 8 дугаар сарын 29-ний өдөр тус тус айлын талд мэдэгдлээ хүргүүлсэн.

Мөн айлын талаас буцаагаад 2022 оны 9 сарын 09-ний өдөр энэ мэдэгдлийг буцааж ирүүлсэн байгаа.

Энэ хүрээнд эдгээр баримт бичгийг цуцалж хүчингүй болгох талаар эрх зүйн баримт бичгийг байгуулж баталгаажуулах шаардлагатай гэж үзсэн.

Мөн “Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэх” гэсэн заалт байгаа.

Энэ хүрээнд 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Засгийн газрын ажлын хэсгийн дарга, тухайн үеийн Х.Нямбаатар сайдаар ахлуулсан ажлын хэсгийн дарга хөндлөнгийн аудитын дүгнэлтийн тухай Оюу Толгой компанид, Рио Тинто зэсийн группэд хүргүүлсэн.

Ингээд энэ хөндлөнгийн аудит хийгдээгүй. Үүнийг удаа дараа шаардаж байгаа. Аудит хийлгэх шаардлагаа хүргүүлсэн. Ингээд аудитыг хийлгэхийг энэ 2025 онд айлын талаас зөвшөөрсөн байгаа.

Мөн Оюу Толгой төслийн гүний уурхай ашиглалтад орж, олборлолт эхлэх хугацаа буюу 2023 оны эхний хагас жил хүртэлх нэмэлт зардлыг гадаад хөрөнгө оруулагч тал 100 хувь хариуцаж өр өсгөхгүй байх нэмэлт... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Гүйцээж хариуля.

**Ш.Мөнхцэрэн:** ...гэсэн заалт байгаа.

Энэ хүрээнд Оюу Толгой компани төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар олонхоороо буюу 6 гишүүний саналаар тогтоолоо батлаад яваад байгаа. Монголын талаас нэмэлт санхүүжилт авах асуудлыг удаа дараа зөвшөөрөхгүй гэдгээр явж байгаа.

Тэгээд ер нь 103, 120 дугаар тогтоолын давхцалыг бид гаргаад одоо энэ бусад ажлын хэсгүүд дээрээ нэмж удирдамжид нь өөрчлөлт оруулаад ингээд ажиллаад явж байгаа.

120 дугаар тогтоолын хүрээнд сая шинээр Монгол Улсын Ерөнхий сайдын 59 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан ажиллаж байгаа.

Тавантолгойн орд дээр Эрдэс баялгийн яам хариулах уу?

**Р.Сэддорж:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам. Тодорхой хариулаарай.

**Ц.Өнөрнасан:** О.Батнайрамдал гишүүний асуултад хариулъя.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ц.Өнөрнасан байна.

Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга арга хэмжээний тухай 2018 оны 6 сарын 29-ний өдрийн 73 дугаар тогтоол гарсан.

Энэ тогтоолд биржээр арилжаалах бэлтгэл ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, 2010 онд багтаан Улсын Их Хуралд танилцуулах, шаардлагатай холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэдэг агуулгатай заагдсан.

Ашигт малтмалын бүтээгдэхүүнийг биржээр арилжаалах асуудал үе шаттайгаар биржээр арилжаалагдаад явж байгаа.

Хамгийн сүүлд зэс дээр биржээр арилжаалах тогтоол, шийдвэрүүд нь гараад явж байгаа.

Аж үйлдвэр эрдэс баялгийн сайдын 2025 оны 175 дугаар тушаалаар Ашигт малтмалын хууль болон түүнийг дагаж өөрчлөгдөх хууль тогтоомжуудад өөрчлөлтийн төслийг боловсруулаад, өнгөрсөн долоо хоногийн Засгийн газрын хуралдаанаар... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулъя.

**Ц.Өнөрнасан:** Үүнд үүнтэй холбогдуулаад энэ Ашигт малтмалын хуулийн өөрчлөлтөд дагаж энэ биржийн хуулийн өөрчлөлтүүд болон холбогдох өөрчлөлтүүд орохоор байгаа.

О.Батнайрамдал гишүүнд энэ талаар тусгайлан мэдээллүүдийг нь өгье.

Их Хурал руу ирэх долоо хоногоос танилцуулагдах байх. Ашигт малтмалын хуулийн өөрчлөлтийг дагаж Биржийн хуульд өөрчлөлтүүд орж байгаа асуудлууд байгаа.

**Р.Сэддорж:** О.Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

**О.Батнайрамдал:** Яах вэ, би энэ Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлт дээр бухимдаад байгаа нь, энэ Улсын Их Хурлын хууль, тогтоолын биелэлтийн ард нь энэ чинь хэдэн их наядын татвар төлөгчдийн мөнгөний захиран зарцуулалтын асуудал яригдаад байгаа байхгүй юу.

Татвар төлөгчдийн мөнгийг захиран зарцуулах үүрэг нь гүйцэтгэх засаглал. Түүн дээр хяналт тавих нь Улсын Их Хурал.

Тэгэхээр энэ тайлан дээр хариуцаж байгаа улс төрийн албан тушаалтнууд байхгүй бол энэ хэдэн их наяд төгрөгийн татвар төлөгчдийн мөнгө хэрхэн захиран зарцуулагдсан юм, Улсын Их Хурлаас баталсан тэр хууль, тогтоолууд хэрхэн хэрэгжсэн гэдэг чинь явж явж энэ Улсын Их Хурлын хувьд ч гэсэн, Засгийн газрын хувьд ч гэсэн үндсэн 5 асуудлын нэг нь шүү.

Тэгэхээр өнөөдөр энэ асуудал дээрээ ийм хандаж байгаад үнэхээр бухимдахын аргагүй байна. Энэ дээр зарчим яриад байгаа юм.

Нэмэлт 1 минут авъя. Тэгэх үү?

**Р.Сэддорж:** О.Батнайрамдал гишүүнд 1 минут.

**О.Батнайрамдал:** Тэгэхээр цаашдаа Их Хурлын гаргасан шийдвэр хэрхэн биелсэн талаар тайлагнал ер нь олон нийтийн өмнө байх ёстой.

Яагаад гэвэл татвар төлөгчдийн өөрсдийнх нь өмнө тэдний мөнгийг хэрхэн захиран зарцуулсан юм. Улсын Их Хурлаас тэдний төлөөлөл ямар хууль тогтоомж батлаад байхад тэр нь яагаад хэрэгжсэн юм. Яагаад хэрэгжээгүйг яг яс юман дээрээ ард түмэндээ тайлагнах ёстой байхгүй юу.

Энэ дэндүү хангалтгүй явж байна. Хэдэн Төрийн нарийнаа урдаа тавьчихаад тэд нар нь нэг гишүүдийн асуултад нэг бувтнасан болоод хариулаад. Ингэж явж болохгүй байхгүй юу. Үүнийг бид засахгүй бол үе үе ингэж аргалаад хэдэн салбарын яамд нь өөрсдийнхөө дүгнэлтийг 92, хувь 100 хувь гээд оруулж ирээд аргалаад өнгөрдөг байж болохгүй.

Цаг хугацааг нь тулгаж ирээд хойшлуулах ч боломжгүй өнөөдөр ийм байдалтай ингэж оруулж ирдэг нь маш том зарчмын хувьд алдаа шүү. Эд нарыгаа засах хэрэгтэй шүү, цаашдаа.

**Р.Сэддорж:** П.Батчимэг гишүүнийг нэмье.

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн.

**С.Цэнгүүн:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

---

Тэгэхээр Хэрэг эрхлэх газраас хиймэл оюун ухаанд суурилсан дүн шинжилгээний тайланг Их Хурлын шийдвэр гаргалтууд дахь давхардал, илүүдэл зохицуулалт дээр гаргаж ирсэн байгааг бид бүхэн харж байна.

Тэгэхээр энэ дээр нэг анхаарал татаж байгаа зүйл нь 2025 оны хугацаанд Улсын Их Хурлаас 1400 гаруй байгууллагууд дээр чиглэл болон тогтоолуудаар зааварчилгаа өгч ажилласан байгаа юм.

Үүнийх нь биелэлтийг нь хараад үзэхээр ерөнхийдөө 51 хувь нь яагаад одоо гарсан байгаа хууль тогтоомжуудыг биелүүлж ажиллахгүй байгаа юм бэ гэдэг дээр анхаарсан байгаа юм.

Тэгэхээр манай Монгол Улсад ерөөсөө хууль тогтоомж дутагдаагүй. Харин гүйцэтгэх түвшинд энэ хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэхгүй байгаад байна гэдэг асуудал байгаа юм л даа.

Тэгээд буцаад үнэлгээгээ гаргаад авахаар нөгөө яамд нь ерөөсөө 100 хувийн гүйцэтгэлтэй гээд л нэг ийм л тайлан ерөөсөө жилийн жилд өгөөд аргацаагаад сурсан ийм байдал ерөөсөө засагдахгүй байгаад байна.

Тэгээд би бас энэ Эдийн засгийн байнгын хорооны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолыг эргэж асуумаар байгаа юм. Эрчим хүчний яамнаас.

Эрчим хүчний яаман дээр уг нь бодлого тодорхойлоод явж байх ёстой. Энэ бодлогодоо юуг тусгах ёстой гэвэл бид бүхэн ер нь энэ өвөл ямар хүнд өвөл болсныг мэдэж байгаа. Тэр дундаа ДЦС-3, ДЦС-4 дээр байдаг үнсэн сангийн тухай асуудал байдаг.

Энэ үнсэн сангууд маань дүүрч байгаа. Ил задгай хэлбэрээр Улаанбаатар хотод үнсэн сангууд хаягдлаа тавьсан. Энэ үнсэн сангийн талбайнууд нь дүүрэхээрээ нийслэлээс ахиад 6, 7 тэрбум төгрөгөөр шинэ газар аваад нөгөө хуучин байгаа үнснүүдээ автомашинаар тээвэрлээд ингээд нэг аргацаасан шийдэл хайж байгаа юм.

Гэтэл энэ 2029 он гэхэд энэ асуудал чинь өндрөө аваад хүнд байдалд хүрнэ.

Тийм учраас Их Хурлаас чиглэл өгөөд энэ асуудлаа эртхэн шийдээч ээ гээд явуулсан байгаа юм.

Тэгээд энэ дээр ямар нэгэн гарц гаргалгаа, шийдлүүд ярьсан уу? Нийслэлтэй энэ асуудлаа шийдэж байгаа юу? Үндэсний тухай асуудлаа яах вэ гэдгийг асуумаар байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас бид бүхэн одоо энэ “Эй Ай” дээр тулгуурлаад асуудлууд маань Улсын Их Хурлаас маш олон чиглэлүүд өгч байна.

Гэтэл энэ нь Улсын Их Хурлаас гаргаж ирсэн тогтоол чиглэлүүдийг нь Засгийн газар дээр очоод цоо шинэ чиглэл, тогтоол өөрсдөө баталж байгаа юм шиг явдаг. Ингээд ирэхээрээ давхардлууд нь бий болоод байна.

Тэгэхээр үүнийхээ уялдаа холбоог яаж хангах вэ? Манайд ер нь шийдвэр гаргалтын инфляц гэж энэ тайлан дээр дүгнэсэн байна. Ийм хямрал үүсчхээд байна. Маш олон гоё гоё цаасан дээр тухайн асуудлыг шийдэх юм шигээр бид бичээд тавьдаг. Хэрэгжүүлэлт байдаггүй.

Тэгэхээр энэ шийдвэр гаргалтуудын уялдаа холбоог нь яаж хангуулах дээр Та бүхэнд төлөвлөгөө байна уу?

**Р.Сэддорж:** Хариулт. Индэр.

**Ц.Өнөрнасан:** С.Цэнгүүн гишүүний асуултад хариулъя.

Үнсэн сангийн асуудал эрчим хүчний салбарын хамгийн хүнд асуудлын нэг болж байгаа. Энэ бол бодит байдал.

— ДЦС-4, Амгалангаас бусад станцууд нь устай хольж үнсээ зайлуулдаг. Тэрийгээ тодорхой талбайд тунгааж сан үүсгэж явдаг.

— ТЭЦ-4 дээр цахилгаанаар үнсээ барьдаг. Үүнийгээ эдийн засгийн эргэлтэд оруулаад барилгын цемент материалд ашиглах боломжтой байгаа.

Тэр агуулгаар нь ТЭЦ-4 дээр өвлийн халаалтын саруудад барилгын сезон эхлээгүй үед нь үнс цуглуулах “силос” гээд үнс хадгалах томоохон вакум савнууд барих ТЭЗҮ хийх ажил ТЭЦ-4-тэй хамтраад эхэлж байна.

Энэ силос гээд энэ байгууламжийг барьвал ТЭЦ-4-өөс нэмж ямар нэг үнсэн сан дүүргэхгүй, шинээр үнсэн сангийн талбай шаардахгүй байх боломжтой байгаа.

ТЭЦ-2-ын үнсэн сан дээр ТЭЦ-5 төслийг нийслэлийн оролцоотойгоор эхлүүлж байгаа.

Шинээр баригдах станц ерөөсөө 100 хувь үнсийг хуурайгаар барина. Энэ нь ямар нэг үнсэн санд хуримтлуулахгүй шууд 100 хувь барилгын материалын үйлдвэрлэлд ашиглахаар төлөвлөлтийг явуулж байгаа.

Амгалангийн дулааны станцын хувьд үнс хадгалах савтай болохоор ер нь нийт гарч байгаа үнснийхээ 80 хувийг барилгын материалын цементийн үйлдвэрүүдэд борлуулж чадаж байгаа.

Ер нь цаашид үнстэй холбоотой, үнсэн сангийн газартай холбоотой асуудал салбарын гол хүндрэлтэй асуудал хэвээр байгаа асуудал байна.

**Ч.Бат-Эрдэнэ:** С.Цэнгүүн гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ байна.

Өнөөдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж дээр улсын хэмжээнд 1348 шийдвэрийн 5688 заалтын биелэлтийг бид улсын хэмжээнд хариуцаад, жилд 2 удаа тайлагнаад явж байгаа.

Их Хурлын түвшинд тухайлаад авч үзэх юм бол 1977 заалт байгаа.

Энэ 1977 заалт дээр Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан хууль тогтоомжийн хэрэгжилт хяналт тавих журмаар энд заасан арга зүйгээр хяналтаа тавиад явж байгаа.

Их Хуралд хүргүүлсэн тайланд хууль тогтоомжийн биелэлтийн дундаж хувь 77.3 хувийн хэрэгжилттэй гэдгийг бид тайлагнасан байгаа.

Их Хурлын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж маань 71 хувьтай, яг Эдийн засгийн байнгын хороонд хамаарах нь 54.5 хувьтай гэсэн үнэлгээ өгсөн.

Энэ үнэлгээг ямар арга зүйгээр хийсэн бэ гэхээр 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан энэ аргачлалын хүрээнд үнэлээд яваад байгаа.

Тэгэхээр энэ хоёр аргачлалаа бид цаашдаа хоёр өөр байх ёстой юм байна. Нийтдээ 9 төрлийн шийдвэр байгаа.

- Хууль,
- Улсын Их Хурлын тогтоол,
- Байнгын хорооны тогтоол,
- Засгийн газраас гарч байгаа шийдвэрүүд,
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж,
- Ерөнхийлөгчийн... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Нэмж хариулъя. Индэр.

**Ч.Бат-Эрдэнэ:** Хяналт тавих, үнэлэх арга зүйгээ тодорхой болгох шаардлагатай байна гэж үзэж байгаа.

Дээрээс нь гишүүний саяын асуултад дурдсан, бид хиймэл оюун ухааны тусламжтайгаар ажлын ачааллаа бууруулах бодитой үнэлдэг энэ асуудал руу шилжих боломж бололцооны талаар бид сүүлийн хагас жилийн түвшинд судлаад явж байгаа.

Үндсэндээ улсын хэмжээнд тайлагнаж байгаа төрийн бүх шатны байгууллагуудын тайлан мэдээгээ шат шатдаа нэгтгэгдээд Засгийн газар дээр төвлөрч байгаа юм.

Тэгэхээр бид тагнуулын байгууллагаас хиймэл оюун ухааныг ашиглаад төрийн бүх байгууллагуудын хууль тогтоомжийн биелэлтийн тайланг хиймэл оюун ухааны тусламжтайгаар бид тодорхой арга, аргачлалын дагуу үнэлж болох уу гэдэг албан ёсны лавлагааг авсан.

Одоогоор бидэнд тийм боломж бололцоо хязгаарлагдмал байна гэдэг хариуг бидэнд өгсөн байгаа.

Гэхдээ бид нийтэд ил байгаа энэ тайлагналтын асуудал дээрээ тодорхой хэмжээнд боломж байна уу гэдгийг манай Мэдээлэл, технологийн хэлтсийнхэн... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Микрофонгүй ярьлаа. Дахиад 1 минут. Товч тодорхой.

**Ч.Бат-Эрдэнэ:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас санаачилгаараа бүх байнгын хороод дээр магадлалыг нь тодорхойлж орж ирсэн.

Эдийн засгийн байнгын хороонд хамаарах 494 заалтад бид энэ хиймэл оюун ухааны тусламжтайгаар аваад үзэхэд –

- 0.6 хувь нь гарч байгаа шийдвэрүүд бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжоор үүрэг, чиглэл болгосон дээр давхцал байх магадлал байна гэж гаргаж ирсэн.
- 27.7 хувь нь Улсын Их Хурлаас гарсан тогтоол, Байнгын хорооны тогтоолуудтай агуулгын хувьд давхардах магадлалууд өндөр байна гэсэн байгаа.
- 7.7 нь батлагдсан бодлогын баримт бичгүүдтэй давхардаж агуулгын хувьд гарч байгаа магадлал байна шүү гэдгийг гаргаж ирсэн байж байгаа.

Тэгэхээр бид энэ удаагийн тайлан дээрээ ийм ажлыг эхлүүлж байна. Дараа дараагийн хагас жил, бүтэн жилийн тайлан дээр бид илүү үүнийгээ албажуулаад, хууль эрх зүйн дүрэм журам дээрээ өөрчлөлт оруулаад үүнийгээ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** С.Цэнгүүн гишүүн тодруулж асууя.

**С.Цэнгүүн:** Мэдээлэл хүргэсэнд баярлалаа.

Тэгэхээр Эдийн засгийн байнгын хорооноос гарсан тогтоол дээр анхаарч харах юм бол 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтааж Эдийн

засгийн байнгын хороонд “Засгийн газарт чиглэл өгсөн тухай” Эрчим хүчний яам тайлагнах үүрэгтэй байгаа.

Тэр утгаараа Эрчим хүчний яам энэ дулааны цахилгаан станцууд дээр үүсээд байгаа үнсэн дээр байгаа асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэх вэ. Бид бүхэн хаягдал үнсээ хаяхын тулд жил болгон 6, 7 тэрбум төгрөг зарцуулах биш. Энэ чинь буцаагаад эдийн засгийн эргэлтэд ороод бид одоо жишээ нь замын чигжээс хийх ч байдаг юм уу. Тэр мэтчилэн барилгын материалын үйлдвэрлэлд ашиглах бололцоотой хөрөнгө орлох боломжтой ийм бүтээгдэхүүн байгаа юм.

Тэгэхээр тайлагнахдаа энэ материалуудаа бэлдээрэй гэж хэлэхийг хүсэж байна.

**Р.Сэддорж:** П.Батчимэг гишүүний нэрийг буцааж аваарай.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн.

**М.Бадамсүрэн:** Ард иргэд, айл өрх, аж ахуйн нэгжийн эдийн засгийн байдал тийм сайжрахгүй байгаа шалтгаануудын нэгийг өнөөдрийн тайлангаас би хараад л дүгнэж байна л даа.

Эдийн засгийн байнгын хороо Улсын Их Хурлын мэргэжлийн Байнгын хороо. Энэ Байнгын хорооны гаргасан тогтоолын хэрэгжилт 43 хувьтай гэж дүгнэгдсэн байна.

Тэгээд оюутан сурагчид 43 хувьтай даалгавраа хэрэгжүүлсэн бол энэ одоо муу юу, сайн уу, хангалттай юу хангалтгүй юу?

Тийм учраас үүнийг би бүх яамдаас яг манай Эдийн засгийн байнгын хорооны гаргасан тогтоол, шийдвэрийн биелэлт, танайд үүрэг болгож өгсөн хамааралтай яамд нь яагаад биелсэн бэ? Яагаад биелээгүй вэ? Үүнийг нэгдүгээрт асууя.

Хоёрдугаарт нь, ер нь яах вэ, тайланг сайн бичдэг хүн байдаг л даа.

Тэгээд нөгөө тайлан талын чинээ, ажил нь алгын чинээ гээд. Тайлан тааруухан бичдэг мөртлөө ажил нь сайн хэрэгжсэн ийм албан тушаалтнууд ч байдаг.

Тэгээд магадгүй энэ дотор чимээгүй ажлаа сайн хийгээд, гүйцэтгэлээ сайн хэрэгжүүлдэг байгууллага, албан тушаалтан би олон байгаа гэж бодож байгаа.

Тэгээд Улсын Их Хурлын Тамгын газрын гаргасан тайланг харахаар аймаг, орон нутгууд хууль, тогтоолын биелэлтийг сайн биелүүлсэн гэж гарч байгаа. Дандаа өндөр хувьтай. Тэгээд яамд болохоор жоохон хангалтгүй байна гэж гарч байгаа юм.

Тэгээд энэ дээр ер нь ямар дүгнэлт хийж байгаа вэ гэдгийг би яамдаас асууя.

Би хамгийн сайн мэдэж байгаа Эдийн засгийн байнгын хорооны гишүүний хувьд 2 тогтоолыг оролцож санаачилж батлуулсан байдаг юм.

- ▷ **Нэгд нь**, ашигт малтмалын нөөц ашигласан, газрын тосны нөөц ашигласан нийт төлбөрийн орлогын 30-аас доошгүй хувийг тухайн орон нутаг, нөлөөлөлд өртөж байгаа бүс нутагт нь хуваарилъя гэдэг.

Тэгээд энэ яах вэ 20 хувь гээд ашигт малтмалын шинэчилсэн найруулга дээр тусгагдаад явж байгаа юм байна.

Тэгээд 30 гэдэг хувийг 20 болгож байгаа юм байна. Өөрөөр хэлбэл Эдийн засгийн байнгын хорооны өгсөн албан ёсны чиглэл биелэгдээгүй гэсэн үг. 10 байсныг 20 болгож. Уг нь 30 болгоё гээд Эдийн засгийн байнгын хороо тогтоол гаргасан.

- ▷ **Хоёрт нь**, Байнгын хорооноос газрын тосны үйлдвэрийн явцыг дүгнэсэн.

Тэгээд жил болгоны эцэст үүнийг байнга танилцуулж бай гэдэг ийм үүрэг тогтоолоор өгсөн.

Тэгээд өнгөрсөн намар танилцуулагдаагүй. Байнгын хороо нь эсэргүүцсээр байтал тэгээд татан буугдсан. Эргээд байгуулахаар төлөвлөж байгаа юм билээ. Тэгээд ийм тогтворгүй. Бодлогууд нь.

Тэгээд үүнийг хэзээ яаж тайлагнах вэ? Ард түмэнд энэ өндөр өртөгтэй газрын тосны үйлдвэрийн явцыг бид жил болгон мэдээлдэг бай. Хэрвээ тухайн жилийн ажлын явц нь хангалтгүй бол хариуцлагын асуудал ярина гэдэг ийм тогтоол гарсан байдаг.

Дараагийнх нь эдийн засгийг бүсчилж хөгжүүлэх бодлого дээр ямар чиглэл яамдад байна вэ?

**Р.Сэддорж:** Хариулт. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар.

**Ц.Өнөрнасан:** М.Бадамсүрэн гишүүний асуултад хариулья.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Засгийн газрын түвшинд хяналтад аваад ажиллаж байгаа. Улсын Их Хурлын нийт шийдвэрийн хэрэгжилтийн дундаж хувийг бид 2025 оны жилийн эцсийн тайлан дээр 77.3 хувийн үнэлгээтэй байна гэдэг ийм.

Байнгын хорооны дундаж 67.9 байна гэдэг ийм үнэлгээг бид тайлан дээрээ ирүүлсэн байгаа.

Тухайлах юм бол Эдийн засгийн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт 71 хувьтай гэдэг ийм үнэлгээтэй ирсэн байгаа.

Ингээд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүрэг хариуцсан нэгж нь Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн хувийг 43 гээд үнэлсэн.

Би түрүүн С.Цэнгүүн гишүүний асуултад хариулахдаа хэлсэн.

Засгийн газрын 2025 оны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих 183 дугаар тогтоол байгаа. Энэ дээр Их Хурлаас гарсан шийдвэрүүдийг ямар арга зүйгээр хэрэгжилтийг нь үнэлэх вэ гэдэг энэ арга зүй байж байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын Тамгын газрын түвшинд яг манай тэр тогтоолын арга аргачлалаар үнэлээд оруулаад ирсэн. Гэхдээ үнэлгээний хувь нь зөрүүтэй байж байгаа.

Тэгэхээр бид цаашдаа энэ дээр юу харагдаж байна гэхээр Их Хурлаас гарч байгаа шийдвэрүүдийг Их Хурлын түвшинд үнэлгээ хийхэд, Засгийн газрын түвшинд үнэлгээ хийхэд тодорхой арга аргачлалуудаа бид нарийвчлах шаардлага байна. Тэгэхгүй энэ дээр зөрүү гарч байгаа юм байна гэдэг асуудал байгаа.

Хоёрт нь, бид цахим системээрээ тодорхой Их Хуралд хамаарах 1900 гаруй шийдвэрүүдээ харилцан хяналтад аваад явахгүй бол тооны хувьд зөрүү гараад байдаг.

Мөн хэрэгжээд дууссан тогтоолуудыг дахин тайлагнах асуудлууд гарч ирээд байгаа.

Тэгэхээр ийм хэд хэдэн шалтгаануудын улмаас хэрэгжилтийн хувь дээр зөрүү гараад байгаа ийм зүйлүүд байгаа. Жишээлэхэд, Засгийн газрын 183 тогтоол дээр хийсэн тэр аргачлал дээр –

- хэрэгжих шатад,
- хэрэгжсэн,
- хэрэгжээгүй,
- хэрэгжилтийн хугацаа тооцох болоогүй –

-гэсэн ийм ангиллууд байж байгаа. Тэгээд дотроо арга зүй нь шалгуур үзүүлэлтүүдээрээ задраад явж байгаа.

Тэгэхээр энэ дээр бид цаашдаа арга зүйгээ нэгтгэх, сайжруулах чиглэлд анхаарч ажиллая гэсэн.

Мөн Засгийн газрын хуралдааны тэмдэглэл байгаа. Энэ тайлан хэлэлцсэнтэй холбоотой. Бид энэ чиглэлд тодорхой ажлуудыг хийх үүрэг чиглэлийг бидэнд өгсөн байгаа.

**Р.Сэддорж:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам.

**Б.Дашпүрэв:** М.Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя.

Аж үйлдвэр эрдэс баялгийн яамнаас 2026 оныг хууль эрх зүйн шинэчлэлийн жил болгон зарлаад, 4 хуульд холбогдох өөрчлөлт болон шинэчилсэн найруулгыг хийхээр ажиллаж байна.

Үүний нэг нь өнгөрсөн долоо хоногт Засгийн газрын хуралдаанд танилцуулагдсан Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл байгаа.

Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслөөр М.Бадамсүрэн гишүүний хэлж байгаатай санал нэг байгаа. Өөрөөр хэлбэл энэ өөрчлөлтийн төслөөр үйл ажиллагаа явуулж байгаа, өөрөөр хэлбэл уул уурхайн үйлдвэрлэлд өртөж байгаа орон нутаг, аймаг, сумд ашигт малтмалын нөөцлөсний төлбөрийг хуваарилах нь зүйтэй гэдэг концепцын хүрээнд манай яамны хувьд анхны ажлын хэсгийн боловсруулсан төсөл яг энэ тогтоолыг хэрэгжүүлж, нөөц ашигласны төлбөрийн 30 хүртэл хувийг орон нутагт нь хуваарилах саналыг боловсруулж хэлэлцүүлсэн.

Тэгээд хууль тогтоомжийн хуулийн дагуу олон нийтээр хэлэлцүүлэх явц, мөн холбогдох голлох үндсэн... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулъя.

**Б.Дашпүрэв:** Яамдаас санал авахад ялангуяа манай Сангийн яам ашигт малтмалын нөөцийн төлбөрийн хуваарь дээр нэлээн тооцоо судалгаа гаргаж тал талаасаа ярилцсаны үндсэн дээр 20 хувь буюу одоо орон нутгийн хөгжлийн санд төвлөрч байгаа мөнгө ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 10 хувь байгаа. Үүнийг хоёр дахин нэмэгдүүлж 20 хувь болгохоор хуулийн төсөл боловсруулагдаад хэлэлцэгдэх шатандаа явж байгаа.

Тэгээд энэ нэмэгдэл өөрчлөлтийг хийснээр бас энэ уул уурхайн салбарт үүсдэг, нэг талаасаа иргэдийн, орон нутгийн эсэргүүцэл мөн энэ үр өгөөжөө шууд хүртэж байгаа хэлбэр гэж салбарын яамны зүгээс үзэж байгаа.

Газрын тосны үйлдвэрийн хувьд Та бүхэн мэдэж байгаа. 2028 оны нэгдүгээр улиралд ашиглалтад орохоор төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Тайлагнах асуудлаар би яг одоохондоо сайн мэдээлэлгүй байгаад байна. М.Бадамсүрэн гишүүнд холбогдох хүмүүсээс... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Г.Эрдэнэбат. Индрийн микрофон. Үнэлгээний аргачлалын зөрүүний талаар тайлбарлая.

**Г.Эрдэнэбат:** Баярлалаа.

Тэгэхээр сая Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тайлангийн дүн шинжилгээ дээр зөрүүтэй байдал үүсээд байгаа нь аргачлалтай холбоотой гэж тайлбарлаж байна.

- ▶ **Нэгдүгээрт**, аргачлалын асуудал бий.
- ▶ **Хоёрдугаарт**, бодит үнэн байдлын асуудал бий.

Тэгэхээр энэ дээр би юу хэлэх гээд байгаа юм гэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайлан, Улсын Их Хурлын Тамгын газраас дүн шинжилгээ хийж байгаа.

- Үнэлгээ өгөөгүй.
- Шинжилгээ хийсэн.

Тэгэхээр тайланд дурдсан зүйлсийн бодит үнэн байдлыг нь шалгаж байгаа юм. Тухайлбал, сая О.Батнайрамдал гишүүний асуусан Тавантолгойн нүүрсний ордтой холбоотой Засгийн газар тайлагнасан байгаа.

2018 оны 73 дугаар тогтоолын заалтаар бэлтгэл ажил хийсэн. 100 хувь биелсэн гээд тайлагнасан боловч үнэн хэрэг дээрээ тайлан дээр зөрүүтэй тайлан хийсэн.

- Тэр тайлан нь Монголбанкны тайлантай зөрсөн.
- Ийм учраас үүнийг хэрэгжээгүй гэж үзсэн.

“Эрдэнэс Тавантолгой” холбоотой дахиад Хятад Улсын хилийн доторх Ганцмод боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит компанийн “20 сая тонноос доошгүй хэмжээний нүүрсийг харилцан ашигтай гэрээ байгуулахыг зөвшөөрөх” гээд заасан.

- “Эрдэнэс Тавантолгой” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг бүртгэсэн боловч үүний тайлан ирээгүй.
- Ийм учраас үүнийг хэрэгжээгүй гэж үзсэн.

Энэ мэтээр тайлан тавих журмаа баримтлаад тайлагнаад эхэлбэл тэр тайланг бид үнэлж хэлэлцэх бололцоотой болно.

Нэг аргачлалаар үнэлж байгаа учраас энд зөрүү гарах учиргүй.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2025 оны 16 дугаар тогтоолоор Тавантолгой түлш ХХК-тай холбоотой 5 заалт бүхий тогтоолын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийн явцыг 2025 оны гуравдугаар

улиралд багтаан Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд танилцуулахыг үүрэг, чиглэл болгосон.

- Энэ тогтоолын биелэлтийг ирүүлээгүй.
- Шийдвэрт заасан хугацаанд Байнгын хороонд танилцуулаагүй учраас тайланд хэрэгжээгүй гэж үзсэн.

Нэгдүгээрт, аргачлалын зөрүүтэй байдал гэхээсээ илүү тайлагнах журам заавраа мөрдөөд ажиллавал энэ дээр янз бүрийн зөрүү гарахгүй байх гэж бодож байна.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа.

Хариулт хангалтгүй гэж үзвэл 1 минут. М.Бадамсүрэн гишүүн хариулт хангалтгүй гэж үзэж 1 минут.

**М.Бадамсүрэн:** Би их тодорхой асуугаад байгаа. Жишээлбэл, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам яахаараа газрын тосны үйлдвэрийн явцыг жилийн эцэст тайлагнана гэдгийг одоо болтол мэдэхгүй байдаг юм.

Тэгээд энэ чинь ажлын чинь үр дүнг харуулаад байгаа шүү дээ.

Тэгээд сая Их Хурлын Тамгын газраас тодорхой хариулт өгч байна.

Тайлан нь талын чинээ, ажил нь алгын чинээ. Тэгээд далан хэдэн хувьтай гээд ирүүлсний чинь 43 хувь гээд л. Үнэн бодит байдалд нийцэх ёстой гээд дүгнэсэн гэдгийг сая хэлэлцүүлэг дээр тайлбарлалаа шүү дээ. Бодит байдал дээр ийм л байгаа шүү дээ.

Нэгэнт төрийн шийдвэр, Байнгын хороо, Их Хурлын тогтоол гарсан бол тухайн албан тушаалтан үүнийг шүүмжлэх тийм боломж байхгүй. Үүнийг заавал хэрэгжүүлээд явах ёстой. Ингэдэг бол өнөөдөр бид өчнөөн олон ажлын ард гарсан байх ёстой.

Яагаад газрын тосны үйлдвэрийн энэ том бүтээн байгуулалтын ажил, 7, 8 их наяд төгрөгийн бүтээн байгуулалтын ажлыг жил болгоны эцэст дүгнэхэд үүнийг одоо болтол дүгнэхгүй байгаа юм? Яагаад ирүүлэхгүй байгаа юм?

**Р.Сэддорж:** Индрийн микрофон. Өөрийгөө танилцуулаад хариулт.

**Л.Наранчимэг:** М.Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя.

“Эрдэнэс Монгол” компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг.

Газрын тос боловсруулах үйлдвэр 7.7 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 4 багцаас бүрдэж байгаа.

Газрын тос боловсруулах үйлдвэр дотроо 4 ЕРС гэрээтэй.

- **ЕРС-1** гэрээнд “технологийн бус барилга байгууламж, зам талбай” байгаа.  
— 100 хувийн хэрэгжилттэй.
- **ЕРС-2** гэрээнд анхдагч “процессын болон дамжуулах байгууламжууд” байгаа.  
— 55 хувийн гүйцэтгэлтэй.
- **ЕРС-3** гэрээнд “үйлдвэрлэлийн цахилгаан станц” байгаа.  
— 41 хувийн гүйцэтгэлтэй.

➤ Гүн боловсруулах лицензийн технологийн байгууламжууд 8.9 хувьтай.

Ингээд үйлдвэрийн бүтээн байгуулалт үндсэндээ 37 хувь гэж хэрэгжилтэд дүгнэгдэж байна.

- ◆ Газрын тос дамжуулах хоолой 89.8 хувийн гүйцэтгэлтэй. Энэ ажил төлөвлөгөөний дагуу нэлээн эрчимтэй сайн явж байгаа.
- ◆ Хотхоны барилга, байгууламж 61 хувьтай байгаа.

**Р.Сэддорж:** Энэ тайланг гаргаж М.Бадамсүрэн гишүүнд өгье. Тийм. Асуусан гишүүдэд хариултуудыг бичгээр өгөөд явахгүй бол үл ойлголцол.

Хариулт л нэхээд байгаа шүү дээ. Энэ дээрээ анхааръя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа.

**Б.Пунсалмаа:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Улсын Их Хурлаас гаргасан хууль тогтоомжийн шийдвэрийн биелэлтийн тайланг сонсож байна.

Тэгээд 2025 онд Улсын Их Хурлын Тамгын газарт нийтдээ –

- хууль тогтоомж 157,
- Улсын Их Хурлын тогтоол 174,
- Байнгын хорооны тогтоол 114 орж ирсэн байгаа.

Гэтэл биелэлт нь 58.5 хувь гээд. Энэ бол ерөөсөө тун хангалтгүй биелэлт гарч ирж байгаа байхгүй юу. 58.5 хувь.

Тэгээд энэ тайлангийн дүгнэлт дээр ийм дүгнэлт орж ирсэн байх юм.

Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг байгууллагуудыг Засгийн газарт хяналт-шинжилгээ, тайлангийн цахим санг ашигладаг болох арга хэмжээ цаашид авч хэрэгжүүлнэ гэсэн байгаа.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам чинь хэдэн онд байгуулагдсан билээ? Хэдэн жил болсон билээ? Одоо болтол Улсын Их Хурлын бүтцийн байгууллагууд, Засгийн газар хэрэглэх Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны тайлангаа нэгтгээгүй, цахимжуулаагүй явж байгаа юм уу?

Энэ ажил нь хэдэн хувьтай байдаг юм?

Энэ жил үүнийг зорилт болгоод оруулж ирж байгаа юм байна. Энэ зорилтын хүрээнд цахимжуулах, нэгтгэсэн тайлан гаргах дээр Цахим хөгжлийн яам ямар ажил, алхмууд харж байгаа юм? Жилийн эцэст нэг удаа тайлагнадаг юм уу, эсвэл улирал улиралдаа тайлагнаад, үр дүнгээ нэгтгээд хараад дүгнээд явдаг юм уу? Энэ талаар Цахим хөгжлийн яамнаас асууя.

**Р.Сэддорж:** Индрийн микрофон дээр өөрийгөө танилцуулаад хариулъя.

**Б.Мягмарнаран:** Сайн байна уу? Гишүүний асуултад хариулъя.

Цахим хөгжил, Инновац, Харилцаа холбооны яам Б.Мягмарнаран.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас бодлогын хувьд хиймэл оюуны үндсэн дэд бүтцийг байгуулах, түүнтэй холбоотой үндэсний хэл “large language model” буюу монгол хэлний моделийг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байгаа.

Яг энэ өнөөдөр тэр ярьж байгаа тайланг нэгтгээд цахимжуулах ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тусдаа өөрсдийн төлөвлөгөөгөөр зохион байгуулж хийж явж байгаа гэж ойлгосон.

Манай яамтай холбогдож энэ талаар яриагүй. Өөрсдийн төлөвлөгөөний дагуу хөгжүүлж байна гэж ойлгосон.

**Р.Сэддорж:** Нэмж хариулах хүн байна уу? Нэмж хариулъя.

**Ч.Бат-Эрдэнэ:** Б.Пунсалмаа гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Бат-Эрдэнэ байна.

Засгийн газрын түвшинд [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) гээд цахим сайт байгаа. Энэ дээр Засгийн газрын түвшний бүх байгууллагуудаараа цахимаар энэ тайлан, биелэлтийнхээ асуудлыг хүлээж аваад хянаад явж байгаа.

Энэ нь 2013 оноос эхэлсэн ажил байгаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих чиг үүрэг 2025 оны 5 сард Засгийн газрын бүтцийн хуульд өөрчлөлт орсноор тус нэгжид энэ чиг үүрэг шилжиж ирсэн. Үүнээс хойш бид бүхэн Улсын Их Хурлын Тамгын газартайгаа хэд хэдэн удаагийн уулзалт хийсэн.

Их Хурал дээр цахимын хяналтын систем, ажлын даалгавар нь гараад сонгон шалгаруулалтаа зарлах байдлаар явж байгаа юм билээ.

Бид энэ 2 системээ хооронд нь уялдуулж өгье. Үүний... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулья.

**Ч.Бат-Эрдэнэ:** Маш олон давуу талууд гарна.

Тийм учраас энэ дээр хэрхэн хамтарч ажиллах талаарх саналуудаа илэрхийлээд Их Хурлын Тамгын газрын холбогдох албан тушаалтнуудтайгаа хоёроос гурван удаагийн уулзалтыг бид хийсэн байгаа.

Тэгээд цаашдаа Их Хурлын харьяа байгууллагуудыг нэгтгэх, Их Хурал Засгийн газрын түвшний системүүд хоорондоо интеграц хийх боломж бололцоог бүрдүүлэх. Цаашдаа Их Хурлын Байнгын хороод гарсан шийдвэрийнхээ хэрэгжилтийн явцыг бодит цагийн горим дээр ороод хардаг болох энэ зорилтыг тавиад бид ажиллаж байгаа.

Харамсалтай нь тодорхой хөрөнгө санхүүгийн нөхцөл бололцоо нь хангалтгүй байна. Хүссэнээр энэ нь тавигдаж өгөхгүй байгаа учраас зорилт маань шуурхай явахад жоохон хүндрэлтэй байгаа. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Хөрөнгө, санхүү хэрэгтэй байна ч гэж. Мэдэхгүй дээ.

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний шийдвэрийн биелэлт нийт дүнгээрээ 54.5 хувьтай байна гэж дүгнэсэн байна. Тэгээд яагаад ийм хувьтай байна.

Улсын Их Хурлаас хэрэгжүүлэх боломжгүй шийдвэрүүдийг батлаад байна гэж үзэж байна уу? Үгүй бол хэрэгжихгүй байгаа шалтгаан нь юу байна вэ гэдэг дээр базаад хариулаадхаач ээ.

Бид олон шийдвэрийг хэрэгжих хугацаа болоогүй гэсэн шийдвэрүүдийг их оруулсан байх юм. Тийм бол үүнийг заавал хэрэгжилтэд нь оруулж тооцоод, нийт хувийн дүнгээ ингээд бууруулаад байх шаардлага байгаа юм уу?

Санал бол цаашдаа Улсын Их Хурлаар гарч байгаа шийдвэрүүдийг сайд нар ач холбогдол өгч идэвхтэй оролцуулах, хэрэгжүүлж чадах шийдвэрээ Улсын Их Хурлаар гаргах тал дээр анхаарахгүй бол хэрэгжүүлж чадахгүй шийдвэрүүд гаргаад, тэгээд түүндээ яагаад байгаа юм биш үү. Тэгээд энэ хувь ийм бага байгаа нь шууд дүгнэнэ шүү дээ.

Сая гишүүд хэлж байна шүү дээ. Ийм бага хувьтай дүгнэгдсэн хүн оюутан ямар дүн авах вэ. Ийм учраас энэ дээрээ сайн анхаараач ээ.

Удахгүй Засгийн газраас улсын жилийн төлөвлөгөөг өргөн мэдүүлнэ. Өөрөөр хэлбэл бүтэн жилийн хугацаанд хийх ажил, төлөвлөгөөгөө танилцуулна.

Тэгээд гишүүд үүн дээр идэвхтэй оролцож, дараа нь хэрэгжилтийг нь хянахдаа хэлэлцэх үедээ өгсөн үүрэг даалгавраа нэхэх ёстой. Тэгэхгүй бол Улсын Их Хурлаас шийдвэр гаргаад, хэрэгжилтийг нь орхидог байдлыг зогсоох хэрэгтэй.

Тэгээд энэ ам ажил хоёр зөрөөд байна гэсэн үг. Ийм учраас энэ дээр энд байгаа бүх хүмүүс анхаарч, сайдууд нь хамгийн чухал анхаарах ёстой.

Тэгээд Улсын Их Хурлын шийдвэрүүд яамд дээр биелэлт өндөр байвал Монгол Улсын ажил үйлс сайн явж байгаагийн л шинж. Энэ дээр анхаарах хэрэгтэй байна.

Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Засгийн газрын мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? М.Энхцэцэг гишүүнээр тасалъя.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал.

**О.Батнайрамдал:** Тэгээд 2025 оны гүйцэтгэлийн тайланг ингээд нэг аргалсан болоод л өнгөрөөж байна даа.

Гэхдээ ард түмэн үүнийг өөрөөр харна шүү дээ. Би хүснэгт 5-ыг харж байна л даа. Яамд өөрсдийгөө 72-оос 97 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлээд л.

21 аймгийн Засгийн даргын Тамгын газар, нийслэлтэйгээ дунджаар өөрсдийгөө 90 хувь гэж үнэлээд. Ард түмний амьдрал яг 90, 97 хувь сайжирсан уу. Энэ дээр олон нийт өөрсдөө дүнгээ тавина л даа.

Тэгэхээр Улсын Их Хурлын зүгээс ч гэсэн хууль батлах, тогтоол батлах ажлын 50 хувь. Буцаад баталсан хууль, тогтоолын хэрэгжилт, энэ тайланг авч хэлэлцэх, үүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээн дээр хяналт тавих. Энэ бол бас ажлын 50 хувь байх ёстой.

Энэ 50 хувь сүүлийн 35 жилийн турш орхигдож ирсэн. Бүхэл бүтэн жилийн Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг өнөөдөр ингээд л өнгөрөөж байна шүү дээ.

Яг ийм учраас бидний баталсан зүйлүүд амьдрал дээрээ, хөрсөн дээрээ хэрэгжихгүй. Ард түмний амьдрал руу гэр лүү нь ороод хөргөгчид нь очихгүй.

Хүүхдийнх нь эрүүл мэнд боловсрол руу нь очихгүй байгаагийн үндсэн шалтгаан нь энэ шүү дээ.

Үүнийг ер нь цогцоор нь өөрчилж янзлах зайлшгүй шаардлага тулгарсан юм байна гэж өнөөдөр харлаа.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг харлаа. Улсын Их Хурлын энэ шийдвэрийн биелэлтийг зохицуулах зүйл, заалт дээр зүгээр хугацааны л зүйл тавьсан байна.

- 15 хоногийн дотор өгнө.
- 15 хоногийн дотор хэлэлцэнэ.

Яагаад гэхээр Улсын Их Хурлын гаргаж байгаа шийдвэрийн биелэлт буцаад яг үнэндээ хэлэхэд ард түмэнд тавигдах ёстой байхгүй юу. Олон нийтэд тавигдах ёстой. Татвар төлөгчдөд Та бүхний авсан бидний гүйцэтгэх засаглал аваад захиран зарцуулсан, Улсын Их Хурлаас Та бүхнийг төлөөлж гаргасан энэ шийдвэрүүд хэрхэн биелснийг нь бид өөрсдөд нь тайлагнах аль аль нь үүрэгтэй шүү.

Тэгэхээр энэ бол ер нь яах вэ өнөөдөр биш л дээ. Үе үе аргалж явсан асуудлын нэг байгаа юм. Үүнийг цаашдаа ингэж ерөөсөө аргалж явж болохгүй. Энэ дээр нэг цогц том өөрчлөлт зайлшгүй шаардлагатай байна.

Улс төрийн албан тушаалтан бол яг энэ асуудлыг хийнэ, бодлогоо хэрэгжүүлнэ гэдэг чиг үүргээр гүйцэтгэх засаглалд томилогдож ажилладаг. Буцаад яг хариуцлагын асуудал ярихад тэр гүйцэтгэл хэр хэмжээтэй хэмжигдэхүйц байсан уу. Үүн дээр үндэслэж буцаад шийдвэр нь гарч байх ёстой.

Тэгэхээр тэр шийдвэр нь буцаад иймэрхүү биелэлттэй. Өөрсдийгөө 87, 97 хувь гээд үнэлэхээр чинь.

Тэгээд сая сая Улсын Их Хурлын Тамгын газраас хэлж байна шүү дээ. Адилхан аргачлалаар үнэлж байгаа мөртлөө хоёр шал өөр. Нэг нь 100 хувь хэрэгжсэн гэдэг. Улсын Их Хурлын Тамгын газар яг адилхан аргачлалаар харсан чинь хэрэгжээгүй гэж дүгнэсэн.

Энэ асуудлуудаа бүгдээрээ цогцоор нь шийдэх ёстой шүү. Хэрвээ шийдэгдэхгүй бол өнөөдөр Монгол Улсад тулгамдаж байгаа асуудлаа бид шийдэж чадахгүй байхгүй юу. Энэ бүтэн тойргийнхоо хагасыг нь хийчхээд хагас нь ажиллахгүй болохоор чинь энэ дугуй чинь цаашаагаа өнхрөхгүй шүү дээ.

Тэгэхээр иймэрхүү байдлаар аргалж явдаг асуудлыг ер нь 2025 оноос цаашаагаа өөрчлөхгүй бол бид энд өөрсдийгөө 97 хувьтай үнэлээд л ажил ерөөсөө хийгддэггүй, ард түмний амьдралд ямар ч өөрчлөлт байхгүй ийм л байдалтай байсаар байх юм байна. Үүнийг өөрчлөх хэрэгтэй шүү.

**Р.Сэддорж:** Шударга дүгнэсэн байна гэж үзэж байна шүү. Тийм ээ. Ер нь шударга дүгнэсэн юм биш үү.

Ингээд М.Энхцэцэг гишүүн.

**М.Энхцэцэг:** Тэгэхээр мэдээж Улсын Их Хурлаас гарч байгаа хууль тогтоомжийн биелэлтийг хянаж байгаа, хэлэлцэж байгаа, дүгнэлт гаргаж байгаа энэ үйл ажиллагааны эцсийн том зорилго нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах.

Дээрээс нь энэ хүрээнд бид цаашдаа ямар хууль тогтоомжид өөрчлөлт оруулах ёстой юм, яагаад чухам тэр заалтууд нь хэрэгжихгүй байгаа юм гэдэг дээр дүгнэлт гаргаад олон үйл ажиллагаанууд явагдах ёстой.

Дээрээс нь салбарын сайдуудын үүргээ биелүүлж байгаа эсэх дээр хариуцлагын асуудал яригдаж байх ёстой.

Гэтэл ийм том үйл ажиллагаа маань маш хариуцлагагүй, халтуурын байдлаар зохион байгуулагдаж байна гэж харж байна.

Тэгээд салбарын хуулийг хэрэгжүүлэх ёстой сайдууд нь хүртэл энэ дээр өнөөдөр үйл ажиллагаагаа тайлагнаад сууж байх ёстой. Байхгүй байна.

Тэгээд салбарын сайдууд мэргэжилтнийхээ ард нуугдаад, төрийн нарийнынхаа ард нуугдаад хүрч ирээд тайлагнахгүй, асуудлаа харилцан ярилцаж цаашаа сайжруулахын төлөө л явах ёстой шүү дээ. Гэтэл ийм том үйл ажиллагааг ийм халтуурын байдлаар зохион байгуулж байгаад үнэхээр харамсаж байна.

Тэгээд нэг л их хэлдэг үг нь ерөөсөө л хуулийн хугацаа нь дуусах гээд байгаа, өнөөдөр дуусах гээд байгаа. Хэдүүлээ хууль зөрчнө. Баларна.

Тэгэхээр ийм байдлаар хэдүүлээ улс орныхоо амин чухал асуудалд ингэж хандаж ерөөсөө болохгүй байхгүй юу даа.

Уг нь үүнийг бид маш сайхан ил тод ярьж хэлэлцээд, яагаад энэ хууль нь хэрэгжихгүй байгаа юм. Эсвэл ор тас амьдралд нийцэхгүй хууль тогтоомж гаргасан юм уу. Тэгвэл үүнийгээ цаашид яаж сайжруулах юм гэдэг асуудлаа яриад сайжруулаад явах нь л уг нь үйл ажиллагааны гол зорилго байх. Гэтэл үүнийг маш халтуур байдлаар зохион байгуулж байна.

Дээрээс нь Эдийн засгийн байнгын хорооны бас нэг үүрэг бол мэдээж ялангуяа Эдийн засгийн байнгын хорооноос гарсан хууль тогтоомжид үнэлгээ хийж, хэрэгжилтэд хяналт тавих нь энэ хорооны нэг үүрэг байхгүй юу даа.

Тэгэхээр Эдийн засгийн байнгын хорооноос энэ дээр онцгойлон анхаарал хандуулаад, тэр ажлын хэсэг байгуулна уу, яана уу ямар нэгэн байдлаар энэ үйл ажиллагааг. Хэдийгээр хуулийн хугацаа нь дууссан ч гэсэн ийм үйл ажиллагааг

дахиж зохион байгуулаасай гэж бүр онцгойлон Эдийн засгийн байнгын хорооны даргад хэлмээр байна.

Дараагийн асуудал нь Улсын Их Хурлын гишүүдийн нэг үндсэн үүрэг бол ерөөсөө л хуулийн хэрэгжилтэд хяналт тавих.

Тэгэхээр хяналт тавьж байгаа. Гэтэл нөгөөх нь хэрэгждэггүй. Би сая Эрчим хүчний яаман дээр онцгойлон хэллээ.

Тэгээд л нэг ийм бөөрөнхийсөн үгээр хариулдаг. Тийм ээ. Тэр grid code чинь шинэчлэгдээгүй. Албан ёсны grid code чинь хэдэн оноос хойш шинэчлэгдээгүй. Тэрийгээ хэзээ шинэчлэх юм. 2026 он гэдэг шинэчлэгдсэн grid code-ыг хармаар байна шүү дээ. Байхгүй.

Тэр “техник ашиглалтын дүрэм” нь байхгүй. Шинэчлэгдээгүй. Хамгийн сүүлд хэзээ ч шинэчлэгдсэн юм. Технологи нь шинэчлэгдээд байдаг, хоцрогдоод байдаг. Тэгээд л бөөрөнхийлсөн. Одоо магадгүй ирэх онд дахиад л энэ хуулийн хэрэгжилтийг ярихаар дахиад л энэ бөөрөнхийлсөн хариултаа өгөөд л сууж байна.

Тэгээд л дэлхийд байхгүй тэр нэг өөрөө цэнэглэдэг батарей гэдгээр баахан өндөр үнэтэй, 10 центтэй. Байж болохгүй байхгүй юу даа.

Тэгэхээр тэр дуудлага худалдаагаа маш тодорхой зарлаад, тэр дээд үнэ гэдгээ тавиад зарлаад. Тэгэхгүй дахиад л хуйвалдаад хэдэн нөхдүүд өндөр үнэ тавьж орж ирээд л, дахиад л өндөр үнэтэй сэргээгдэхүүд энд холбогдоно. Энэ дээр онцгойлон анхаараач ээ.

Тэгээд тэр стандарт дээрээ онцгойлон анхаараач ээ.

Тэгээд л нэг ийм хүрээлэн гээд нэг байгууллага байдаг юм. Тэд нар хийдэг юм. Хаана хийж байгаа юм. Хийхгүй байна шүү дээ. Нам хүчдэлийн стандарт хаана байгаа юм. Байхгүй байна шүү дээ. Хүмүүс тогонд цохиулаад үхүүлээд байна шүү дээ.

Тэгээд яагаад энэ дээр сэтгэл чинь өвддөггүй юм. Тэгээд асуухаар нэг ийм бөөрөнхийлсөн хариулт өгчхөөд л байхгүй. Дараа жил дахиад л энэ бөөрөнхийлсөн хариултыг өгнө.

Гэтэл Та бүхэн энэ хэлээд байгаа ажлыг чинь ядаж энэ 6 сарын хугацаанд хийчхээд танд дахиад танилцуулъя гэдэг ч юм уу жоохон ийм ажил хэрэгч байдлаар юмандаа хандаач ээ. Олон жил ингээд явсан яг тэр байдлаараа ерөөсөө өөрчлөхгүй.

Тэгэхээр хэдүүлээ бүр яг энэ үйл ажиллагааг жоохон үр дүнтэй зохион байгуулах дээр онцгойлон анхаараач ээ гэсэн саналыг... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Яг энэ хэлэлцүүлгийг дараагийн удаа Их Хурлын Тамгын газраас өглөө Засгийн газрын хуралдаангүй өдөр өглөө эрт эхлээд. Сайдууд хүрээд ирвэл гишүүд чинь илүү юм асуух гээд байна шүү дээ.

Тийм учраас тэгж зохион байгуулъя. Намрын чуулганаар эхний хагас жилийн тайлан орно шүү дээ.

Бид Төрийн байгуулалтын байнгын хороотой хамтраад жилийн төлөвлөгөөний хэрэгжилтээ ярьсан. Тийм үү. Гишүүдийг өргөн дэлгэр оролцуулж байхаар юм байна гэдгийг Их Хурлын Тамгын газарт хэлье.

Тэгээд бид ингээд яриад байвал яриад л байна.

Тэгээд улс орны ард иргэдийн амьдрал ахуй талаасаа Та бүхэн ажлаа мэдээж чиглүүлж байгаа.

Би ганц хоёрхон жишээ ярья.

Энэ биржийн хуулиас болж, биржийн хуулиар тээвэрлэлтийг худалдан авах ажиллагаанаас авч өгдөг ийм зохицуулалтаас болж олон зуун хүн дампуурч байна. Тэнд. Олон зуун тээвэрчид 350 сая төгрөгөөр машин авсан хүмүүс банк бусад бүх хөрөнгөө алдаад архинд ороод, гэр бүл салаад ингээд дуусаж байна шүү.

Энэ биржийн хууль дээрээс л энэ тээврийг салгаад, тээврийг тухайн биржийн хуулиар тэр тухайн нүүрсээ худалдаж авсан компани нь юугаар тээвэрлэх эрхийг нь тэр хүмүүст нь, худалдан авагчид нь өөрсдөд нь өгсөн явдаг шүү дээ. Ер нь өгчих л дөө. Тэгвэл тэгээд л тэр хүмүүс чинь тэр дотоодын тээврийн аж ахуйн нэгжүүдтэйгээ яриад л, тэр тээврийн үнэ нь зах зээлийн зарчмаараа яваад байвал тэнд олон мянган хүний хүсэлт тэнд байгаа юм. Үүнийг би олон удаа хэлсэн. Тэгээд ерөөсөө хөдлөхгүй юм.

Одоо биржийн хуульд өөрчлөлт оруулъя гэж. Энэ өөрчлөлтөө дорвитой тэр тээвэрт л төр битгий оролцооч ээ. Биржийн хуулиараа нүүрсээ борлуулж байгаа нь сайн байна. Тэр тээвэрт битгий оролцооч ээ. Түүнээс болж олон мянган хүмүүс, тэндээс амьдрал ахуйгаа залгуулж байгаа хүмүүс дампуурсан.

Тэр хамгийн бага үнийг чинь. Худалдан авах ажиллагаа энд байгаа байх. Тийм ээ. Хамгийн бага үнийг чинь хэн өгдөг юм. Маш баян гадаадын хятад компани өгдөг байхгүй юу. Машины эзэн. Монголын тэр 350 саяар авсан машинтай хүн өгч чадахгүй. Хэрвээ тийм бага үнэ өгвөл бас дампуурна.

Тэгээд 350 саяар авсан тэр машинаа 100 саяар зараад бүр дуусгая, салъя. Би дампуураад гүйцлээ гэсэн ийм юмнууд л ярьж байна.

Тэгээд Боловсролын яам, Хөдөө аж ахуйн яам аягүй сайн хоорондоо уялдаж ажиллахгүй хөдөө нутаг чинь.

Энэ удаагийн Улсын Их Хурал махны экспортыг хориогүй учраас махны үнэ өндөр болж, хөдөө нэг амсхийж байна шүү дээ. Бусдаар бол ингээд хөдөө амьдрах ямар ч боломжгүй болсон.

Тэгээд 6 настнуудыг нь сургуульд нь аваад явдаг. 6 настай хүүхдээ ганцааранг нь явуулах эцэг, эх байхгүй. Тэгээд сумын төв рүү нэг нь яваад өгдөг. Үлдсэн айл нь нөгөө хөрөнгөө хараад үлддэг. Тэгээд эхнэр хүүхэдгүй, ганц бие нөхдүүд чинь архинд орж байна.

Тэгээд малаа зараад төв рүү орж байна. Тийм ээ.

Тэгээд хөдөө нутаг чинь эзгүйрнэ шүү дээ.

Тэгээд 6, 7 настнуудад явуулын багш нар аваачаад энэ зайны сургалт. Бид чинь ковидын ачаар гэх юм уу, онлайнар дажгүй сурдаг боллоо шүү дээ. Хурал хийдэг боллоо шүү дээ.

Тэгэхээр ийм хууль эд нарыг санаачилж байгаа. Тэгээд үүнийг холбогдох яамд маань дэмжиж өгөөрэй. Тэгээд удам залгасан малчин байхгүй боллоо шүү. Үүнийг хэлье.

Тэгээд Та бүхэнд ажлын амжилт хүсье.

Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцаж дууслаа. /алх цохив/

Ингээд Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудал дуусаж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

Ажлын хэсэгт орж ирсэн бүх хүмүүстээ баярлалаа.

Хуралдаан 2 цаг 05 минут үргэлжилж, 12 цаг 53 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**ЦАЛТАН-ОД**